



ИНД-1

Иргэний Нисэхийн Багц Дүрэм

Тодорхойлолт ба Товчлол

Иргэний нисэхийн ерөнхий газар

Дүрмийн тайлбар

ИНД-1 нь Иргэний нисэхийн дүрмүүдэд ашиглагдаж буй нэр томъёо болон товчлолуудыг агуулсан бөгөөд эдгээр дүрмийг тайлбарлахад хялбар болгох зорилготой.

ИНД-1-д:

- Иргэний нисэхийн дүрмүүдэд ашиглагдаж буй тусгай нэр томъёоны тодорхойлолтууд; болон
- Иргэний нисэхийн дүрмүүдэд ашиглагдаж буй товчлолууд багтсан.

Энэ дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Сайдын баталсан ИНД-1-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-1, түүний өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг дүрмийн зохицуулалтад шилжих тухай Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/ -ын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг Шинэ Зеландын Иргэний нисэхийн дүрэмд уялдуулан гаргасан болно.

ИНД-1 нь анх 2007 оны 10 сарын 1-нд хүчинтэй болсон бөгөөд дараах өөрчлөлтийг багтаасан:

Өөрчлөлтийн дугаар

Хүчинтэй болсон огноо

Өөрчлөлт 1

2010 оны 6 сарын 30.

Өөрчлөлт 2

20 ... оны ... сарын ...

ИНД-1-ийг Шинэ Зеландын Part 1-ийн 2015 оны Өөрчлөлт 49-д үндэслэн боловсруулсан болно.

Тэмдэглэл: ИНД-1-ийг англи болон монгол хэл дээр боловсруулсан ба эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хувилбартай нь харьцуулна.

Гарчиг

1.1. Тодорхойлолт	5
1.3 Товчлол	70

1.1. Тодорхойлолт

Энэ Дүрмийн зорилго нь иргэний нисэхийн үйл ажиллагаанд нийтлэг хэрэглэгддэг нэр томъёоны тодорхойлолт болон товчлолын талаар нэгдсэн ойлголт өгөхөд оршино.

Агаарын хөлөг /Aircraft гэж агаар, газрын гадаргуугийн харилцан үйлчлэлээс бусдаар, агаартай харилцан үйлчилснээр агаар мандалд хөөрөн тогтдог аливаа төхөөрөмжийг;

means any machine that can derive support in the atmosphere from the reactions of the air otherwise than by the reactions of the air against the surface of the earth:

Агаарын хөлгийн категори / Aircraft category and category of aircraft гэж агаарын хөлгийн дараах аль нэг ангиллыг: онгоц, бөмбөлөг, глайдер, ханг-глайдер, нисдэг тэрэг, эсхүл микролайт;

means any one of the following classes of aircraft: aeroplane, balloon, glider, hang glider, helicopter, or microlight:

Хөлгийн дарга /Pilot-in-command гэж аливаа агаарын хөлгийн хувьд, тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаа болон аюулгүй байдлыг хариуцсан нисгэгчийг;

in relation to any aircraft, means the pilot responsible for the operation and safety of the aircraft:

Агаарын хөлгийн хөдөлгүүр /Aircraft engine гэж агаарын хөлгийн давших хөдөлгөөн хийхэд ашигладаг, эсхүл ашиглахад зориулагдсан, түүний ажиллагаанд зайлшгүй шаардлагатай, сэнснээс бусад, турбо хүч нэмэгдүүлэгч, аппарат болон туслах хэрэгслүүдийг багтаасан хөдөлгүүрийг;

means an engine that is used or intended to be used for propelling aircraft, and includes turbo-superchargers, appurtenances and accessories necessary for its functioning, but does not include propellers:

Агаарын хөлгийн радио станц /Aircraft radio station гэж:

- (1) зориулалтын үүргийг гүйцэтгэхэд шаардагдах, цахилгаан системийн сүлжээ, холбох кабель, хянах хэрэгслүүд болон антеннуудыг багтаасан, тухайн агаарын хөлөгт суурилуулсан радио төхөөрөмжүүд;
- (2) ИНД-91-ээр авч явахыг шаардсан, бүх зөөврийн ослын радио тоног төхөөрөмж;

means —

- (1) all installed radio equipment including antennae, indicators, controls, interconnecting cabling, and wiring into the aircraft electrical system, which are required in order to perform the intended function; and
- (2) all portable emergency radio equipment required to be carried by Part 91:

Агаараас хүнд агаарын хөлөг /Heavier-than-air aircraft гэж аэродинамикийн хүчний үйлчлэлээр өөрийн гол өргөх хүчээ үүсгэж, хөөрдөг аливаа агаарын хөлгийг;

means any aircraft deriving its lift in flight chiefly from aerodynamic forces:

Иргэний агаарын тээврийн үйл ажиллагаа / Air operation гэж агаарын тээврийн үйл ажиллагаа, арилжааны тээврийн үйл ажиллагаа, эсхүл чөлөөт нисэхийн үйл ажиллагааг;

means an air transport operation, a commercial transport operation, or an adventure aviation operation:

Агаарын тээврийн үйл ажиллагаа /Air transport operation гэж зорчигч, эсхүл барааг агаараар хөлс, эсхүл шан урамшуулалтай тээвэрлэх, дараахаас бусад үйл ажиллагааг-

- (1) арилжааны тээврийн үйл ажиллагаа – ИНД-135 /GA AOC/;
- (2) чөлөөт нисэхийн үйл ажиллагаа - ИНД-115;
- (3) нисдэг тэрэгний дүүжинт тээврийн үйл ажиллагаа - ИНД-133;
- (4) хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа - ИНД-137;
- (5) танилцах нислэг.

means an operation for the carriage of passengers or goods by air for hire or reward except—

- (1) a commercial transport operation;
- (2) an adventure aviation operation under Part 115;
- (3) a helicopter external load operation under Part 133;
- (4) an agricultural aircraft operation under Part 137;
- (5) a trial flight.

Агаарын тээвэрлэгч /Air operator гэж дараах гэрчилгээ эзэмшигчийг:

- (1) Иргэний нисэхийн тухай хууль болон ИНД-119-ийн дагуу олгогдсон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ; эсхүл
- (2) ИНД-129-ийн дагуу олгогдсон гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ;

means the holder of—

- (1) an air operator certificate granted under the Act and in accordance with Part 119; or
- (2) a foreign air operator certificate granted in accordance with Part 129.

Агаарын хөлгийн зөвшөөрөгдөх тоног төхөөрөмж /Justifiable aircraft equipment гэж агаарын хөлгийн тухайн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай аливаа тоног төхөөрөмжийг хэлнэ. Үүнд, агаарын хөлгийн ашигт ачааллын максимум багтаамжийг нэмэгдүүлэхийн тулд хоосон жинг өөрчлөх зорилгоор байнга, эсхүл бусад байдлаар тусгайлан суурилуулсан тоног төхөөрөмж, эсхүл тэнцвэржүүлэгч багтахгүй;

means any equipment necessary for the operation of the aircraft. It does not include equipment or ballast specifically installed, permanently or otherwise, for the purpose of altering the empty weight of an aircraft to meet the maximum payload capacity:

Тогтмол агаарын тээврийн үйлчилгээ / Regular air transport service гэж үйл ажиллагаа эрхлэгчийн санал болгосон, аливаа дараалсан 28 хоногийн хугацаанд хоёр, эсхүл түүнээс дээш аэродромын хооронд, дөрөв, эсхүл түүнээс дээш удаа гүйцэтгэх агаарын тээврийн үйл ажиллагаанаас бүрдсэн үйлчилгээг;

means a service offered by an operator consisting of four or more air transport operations between two or more aerodromes in any consecutive 28 day period:

Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр /Air operator security programme гэж Агаарын тээвэрлэгчийн зорчигчид, багийн гишүүд, газрын ажилтнууд, агаарын хөлөг болон байгууламжийг хууль бус халдлагаас хамгаалахад чиглэсэн хөтөлбөрийг;

means a programme to safeguard an air operator's passengers, crew, ground personnel, aircraft, and facilities from acts of unlawful interference

Арилжааны тээврийн үйл ажиллагаа / Commercial transport operation гэж агаараар зорчигч, эсхүл барааг хөлс, эсхүл шан урамшуулалтай тээвэрлэх үйл ажиллагааг:

(1) үүнд:

(i) зорчигч бүр нь тухайн үйл ажиллагаанд ажил, эсхүл үүрэг гүйцэтгэж байгаа, эсхүл гүйцэтгэх сургалт хийж байгаа; эсхүл

(ii) бөглүү аэродромоос, эсхүл бөглүү аэродром руу зорчигч, эсхүл эд бараа тээвэрлэж байгаа,

(2) дээрх (1)-ээс гадна, дараах үйл ажиллагаа-

(i) ИНД-133-ын дагуу гүйцэтгэж буй нисдэг тэрэгний дүүжинт тээврийн үйл ажиллагаа; эсхүл

(ii) ИНД-137-ийн дагуу гүйцэтгэж буй хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа;

means an operation for the carriage of passengers or goods by air for hire or reward—

(1) where—

(i) each passenger is performing, or undergoing training to perform, a task or duty on the operation; or

(ii) the passengers or goods are carried to or from a remote aerodrome—

(2) except those operations in paragraph (1) that are—

(i) a helicopter external load operation conducted under Part 133; or

(ii) an agricultural aircraft operation conducted under Part 137:

Ачаа /Cargo гэж шуудан, нөөц сэлбэг/хангалт болон тээшнээс бусад, агаарын хөлөгт тээвэрлэж буй аливаа өмч хөрөнгийг;

means any property carried on an aircraft other than mail, stores and baggage

Нутаг дамнасан нислэг /Cross-country flight гэж нисэн гарсан аэродромын төвөөс 46 км-ээс хол, чиг шулуун зайд үйлдэх нислэгийг;

means a flight which extends more than 25 nautical miles (46 km) in a straight line distance from the centre of the aerodrome of departure:

Анхааруулах /Түгшүүрийн үйлчилгээ /Alerting service гэж эрэн хайх, авран туслах тусламж шаардлагатай агаарын хөлгийн талаар холбогдох байгууллагуудад мэдээлэх, шаардлагатай бол эдгээр байгууллагад дэмжлэг үзүүлэх нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг;

means an air traffic service provided to notify appropriate organisations regarding aircraft in need of search and rescue aid, and to assist such organisations as required

Ослын шүхэр /Emergency parachute гэж ослын үед хүмүүс ашиглахад зориулан бүтээгдсэн шүхрийн иж бүрдлийг;

means a parachute assembly designed and intended to be used by persons in an emergency:

Бараа /Goods гэж шуудан болон амьтныг багтаасан, бүх төрлийн хөдлөх өмч хөрөнгө;

means all kinds of moveable property, including animals and mail:

Аюултай бараа /Dangerous goods гэж бусдын эрүүл мэнд, аюулгүй байдал, өмч хөрөнгө, эсхүл хүрээлэн буй орчинд эрсдэл учруулж болох дараах биет зүйлс болон бодисыг:

(a) ICAO-ийн Аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх Техникийн Зааварчилгааны дагуу ангилагдсан, эсхүл түүнд тусгагдсан; эсхүл

(b) ICAO-ийн Аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх Техникийн Зааварчилгааны дагуу аюултай бараа гэж ангилагдаж болох шинж чанар бүхий эд зүйлс, эсхүл бодис.

means articles or substances that are capable of posing risk to health, safety, property, or the environment and—

(a) are listed in, or classified in accordance with, the ICAO's Technical Instructions for the Safe Transport of Dangerous Goods by Air; or

(b) have properties that would result in the articles or substances being classified as dangerous goods under the ICAO's Technical Instructions for the Safe Transport of Dangerous Goods by Air:

Аэродром /Aerodrome гэж-

(1) бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн агаарын хөлгийн буулт, хөөрөлт болон гадаргуу дээрх хөдөлгөөнд ашиглахад зориулагдсан, эсхүл зохион бүтээгдсэн, газар, эсхүл усан дээр тогтоогдсон аливаа талбай; болон

(2) тухайн аэродром, эсхүл түүний захиргааны удирдлагатай холбоотой ашиглаж буй аливаа талбай дээрх, эсхүл ийм газрын

ойролцоох/зэргэлдээх аливаа барилга байгууламж, тоног төхөөрөмж болон суурилуулалт багтана;

(1) means any defined area of land or water intended or designed to be used either wholly or partly for the landing, departure, and surface movement of aircraft; and

(2) includes any buildings, installations, and equipment on or adjacent to any such area used in connection with the aerodrome or its administration:

Аэродромын удирдлагын үйлчилгээ /Aerodrome control service гэж аэродромын хөдөлгөөнийг удирдлагаар хангадаг нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээг;

means an air traffic control service provided for the control of aerodrome traffic:

Аэродромын удирдлагын цамхаг /Aerodrome control tower гэж аэродромын хөдөлгөөнд нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэхээр тогтоогдсон нэгжийг;

means a unit established to provide ATC service to aerodrome traffic:

Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ /Aerodrome flight information service гэж тухайн аэродромын бүсэд нислэгийг аюулгүй, үр дүнтэй гүйцэтгэхэд хэрэгтэй зөвлөгөө болон мэдээлэл өгөх зорилгоор үзүүлж буй үйлчилгээг;

means a service provided for the purpose of giving advice and information useful for the safe and efficient conduct of flights in the vicinity of an aerodrome:

Аэродромын давтамжид хариулах хэсэг /Aerodrome Frequency Response Unit гэж агаарын хөлгөөс дамжуулсан модуляцлагдсан VHF-ийн долгионыг тухайн тохирох давтамж дээр хүлээн аваад, нисгэгчийн радио давтамжийн сонголтыг үг яриа, эсхүл дуут дохионы аль нэгээр баталгаажуулан автоматаар хариу дамжуулдаг, газарт байрласан VHF радиог;

means a ground based VHF radio, which on receipt of a modulated VHF transmission from an aircraft on the appropriate frequency, automatically transmits either a voice or a tone response to confirm the pilot's radio frequency selection:

Аэродромын үйл ажиллагааны бүс / Aerodrome operational area гэж:

(1) аэродром дээрх хөдөлгөөний бүс, түүний холбогдох зурвас, аюулгүй байдлын талбай; болон

(2) агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор аэродром дээр суурилуулсан аливаа газрын тоног төхөөрөмж, эсхүл байгууламжийг;

means—

(1) the movement area at an aerodrome and its associated strips and safety areas; and

(2) any ground installation or facility provided at an aerodrome for the safety of aircraft operations

Аэродромын хөдөлгөөн / Aerodrome traffic гэж:

(1) тухайн аэродромын маневрын талбай дээрх бүх хөдөлгөөн; болон

(2) тухайн аэродромын бүсэд нисэж буй бүх агаарын хөлгийг;

means—

(1) all traffic on the manoeuvring area of an aerodrome; and

(2) all aircraft flying in the vicinity of an aerodrome:

Аэродромын хөдөлгөөний схем /Aerodrome traffic circuit гэж аэродромын бүсэд үйл ажиллагаа явуулж буй агаарын хөлгийн хайрцаг нислэгийн замыг;

means the pattern flown by aircraft operating in the vicinity of an aerodrome:

Аюулгүйн хамгаалалтын мэдэгдэл /Declaration of security гэж ИНД-109-ийн шаардлагын дагуу ачаа, эсхүл шуудангаар илгээх барааны талаар үйлдсэн мэдүүлэгийг;

means a declaration made in accordance with the requirements of Part 109 regarding a consignment of cargo or mail:

Аяллын түвшин /Cruising level гэж нислэгийн чухал ач холбогдолтой хэсгийн турш хадгалсан түвшинг;

means a level maintained during a significant portion of a flight:

Апрон / Apron гэж зорчигч суулгах, эсхүл буулгах, ачаа ачих, эсхүл буулгах, түлшээр цэнэглэх, **зогсоолд тавих**, эсхүл техник үйлчилгээ хийх зорилгоор агаарын хөлгийг байрлуулахад зориулсан, газрын аэродром дээр тогтоосон талбайг;

means a defined area on a land aerodrome intended to accommodate aircraft for the purpose of loading or unloading passengers or cargo, refuelling, parking, or maintenance:

Апрон удирдлагын үйлчилгээ /Apron management service гэж апрон дээрх агаарын хөлөг, тээврийн хэрэгслийн ажиллагаа болон хөдөлгөөнийг зохицуулах үйлчилгээг;

means a service provided to regulate the activities and the movement of aircraft and vehicles on an apron:

Нисэхийн мэдээллийн зохицуулалт ба хяналт /AIRAC гэж нийтлэг хүчинтэй хугацаанд суурилсан, урьдчилсан мэдээллээр хангах зорилготой, үйл жиллагаанд чухал ач холбогдолтой өөрчлөлтийг шаардсан нөхцөл байдлыг онцлон тодорхойлох нисэхийн мэдээллийн зохицуулалтын болон хяналтын тогтолцоог;

[AIRAC-ийн тогтолцоо нь 28 хоногийн үечлэлтэй (1991 оны 01-р сарын 10-наас эхлэн), олон улсад нийтлэг ашиглагддаг хүчинтэй болох өдрүүдээс бүрддэг]

means aeronautical information regulation and control, signifying a system aimed at advance notification based on common effective dates, of circumstances that require significant changes in operating practices:

[The AIRAC system is based upon the international series of common effective dates at intervals of 28 days including 10 January 1991]

AWIB үйлчилгээ /AWIB Service гэж тусгайлан нисэхийн үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор аэродромын болон цаг уурын мэдээллээр хангах автомат мэдээллийн үйлчилгээг (AWIB үйлчилгээ нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ биш);

means an automatic broadcast of aerodrome and weather information provided specifically for the facilitation of aviation, an AWIB service is not an air traffic service

Нисэхийн мэдээллийн эмхэтгэлийн үйлчилгээ /AIP service гэж Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (НМЭ), НМЭ-ийн өөрчлөлт, НМЭ-ийн нэмэлт болон Нисэхийн мэдээллийн цувралуудыг хэвлэх үйлчилгээг;
means a service for the publication of the AIP Mongolia, AIP Amendments, AIP Supplements and aeronautical information circulars:

Ашиглалт хязгаарлагдсан / Lifered гэж нисэхийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсэгт нислэгт тэнцэх чадварын байнгын хадгалалтын зааварчилгаагаар тогтоосон дараах хугацааг:

- (1) тухайн нисэхийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсгийн ашиглалт хязгаарлагдсан нийт цаг, эсхүл
- (2) тухайн нисэхийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсэгт зөвлөсөн, эсхүл заавал хийх их засварын цаг;

means that the instructions for continued airworthiness for the aeronautical product, product, or component specify—

- (1) a finite life time for the aeronautical product, product, or component; or
- (2) a recommended or mandatory overhaul time for the aeronautical product, product, or component:

Агаараас хөнгөн агаарын хөлөг / Lighter-than-air aircraft гэж өөрийн хөвөх чадвараар давамгайлсан агаарт тогтдог аливаа агаарын хөлгийг;

means any aircraft supported chiefly by its buoyancy in the air:

Ажиллагаатай /Operable гэж тоног төхөөрөмж, хэрэгслийн хувьд бүрэн ажиллагаатай, тохируулагдсан болон холбогдох нислэгт тэнцэх чадварын шаардлага хангасныг;

in relation to equipment and instruments, means fully functional, calibrated, and meeting the applicable airworthiness requirements:

Ашиглалтын цаг /Time in service гэж техник үйлчилгээний цагийн бүртгэл, агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэр болон ижил зорилгын хувьд, тухайн агаарын хөлөг гадаргуугаас тасарснаас/гадаргууг орхисноос, буухаар дахин газардах хүртэл үргэлжилсэн хугацааг;

means, for maintenance time records, aircraft log records, and similar purposes, the elapsed time from the aircraft leaving the surface until touching it again on landing:

Ашигт ачааллын багтаамж / Payload capacity гэж:

- (1) түлшгүй максимум жин нь тогтоогдоогүй бол, тухайн агаарын хөлгийн хөөрөлтийн гэрчилгээжсэн максимум жингээс хоосон жин, агаарын хөлгийн нэмэлт тоног төхөөрөмжийн жин болон дараахаас бүрдсэн үйл ажиллагааны ачааллыг хасаж тооцсон:

(1) when a maximum zero fuel weight is not prescribed, the maximum certificated takeoff weight of an aircraft, less the empty weight, less all justifiable aircraft equipment, and less the operating load consisting of—

- (i) ИНД-ийн дагуу, ИХНД / VFR-ийн цаг агаарын нөхцөлд, 322 км (174 nm)-ээс хол зайтай орон нутгийн нисэх буудлуудын хоорондох нислэгт шаардсан тухайн түлшний минимум жин;
- (ii) Маягийн гэрчилгээний өгөгдлийн хуудсанд заагдсан тосны багтаамжийн максимумыг, эсхүл 160 кг тосны аль бага жин;
- (iii) шаардлагатай нисэх багийн гишүүн тус бүрийг 91 кг-аар;
- (iv) шаардлагатай катерингийн хангалт; эсхүл

(2) Түлшгүй максимум жин нь тогтоогдсон бол, түлшгүй максимум жингээс, хэрэглэгдэх түлш, тос ороогүй хоосон жин болон дараах ачааллыг:

- (i) агаарын хөлгийн нэмэлт тоног төхөөрөмжийн жин болон дараах үйл ажиллагааны ачааллын жин;
- (ii) минимум нисэх багийн гишүүн тус бүрийг 91 кг-аар;
- (iii) шаардлагатай катерингийн хангалт;

means—

(1) when a maximum zero fuel weight is not prescribed, the maximum certificated takeoff weight of an aircraft, less the empty weight, less all justifiable aircraft equipment, and less the operating load consisting of—

- (i) the minimum weight of fuel required under the CAR for a flight between domestic points 174 nm apart, assuming VFR weather conditions; and
- (ii) the lesser of the maximum oil capacity as specified on the Type Certificate Data Sheet or 160 kg of oil; and
- (iii) required flight crew members at 91 kg per crew member; and
- (iv) required catering supplies; or

(2) when a maximum zero fuel weight is prescribed, the maximum zero fuel weight less the empty weight that, except for disposable fuel and oil, consists of—

- (i) all justifiable aircraft equipment, and the operating load; and
- (ii) minimum flight crew at 91 kg per crew member; and
- (iii) required catering supplies: /

Зохицуулалттай агаарын ачааны байгууллага / Regulated air cargo agent гэж ИНД-109-ийн дагуу олгогдсон, зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээ эзэмшигчийг;

Аюулгүй байдлын үзлэг /Screening гэж техникийн, эсхүл бусад арга хэлбэрээр хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай төхөөрөмж, эд зүйл, эсхүл бодисыг илрүүлэх ажиллагааг;

Аюулгүйн хамгаалалт / Security гэж иргэний нисэхийг хууль бус халдлагаас хамгаалах зорилго бүхий, хүн, материаллаг эх үүсвэр болон арга хэмжээний нэгдлийг;

Security means a combination of measures and human and material resources intended to safeguard civil aviation against acts of unlawful interference:

Аюулгүйн хамгаалалтын бүс / Security area гэж Дарга, хуулийн дагуу хамгаалалттай байхаар заасан талбайг;

means an area that the Director has declared to be a security area under the Act:

Аюулгүйн хамгаалалтын хяналт / Security control гэж хууль бус халдлагад ашиглаж болзошгүй зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, эсхүл бусад аюултай төхөөрөмж, эд зүйл, эсхүл бодисыг агаарын хөлөгт, эсхүл аэродромд нэвтрэхээс урьдчилан сэргийлэхэд ашиглаж буй аргыг;

means a method used to prevent the introduction on board an aircraft or at an aerodrome of a weapon, explosive or other dangerous device, article or substance that may be used to commit an act of unlawful interference:

Аюулгүйн хамгаалалттай аэродром /Security designated aerodrome гэж хуулийн дагуу, тухайн цаг хугацаанд хамгаалалттай аэродром гэж тогтоосон аэродромыг;

means an aerodrome for the time being designated as a security aerodrome under the Act:

Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүс / Security enhanced area гэж Дарга хуулийн дагуу өндөржүүлсэн хамгаалалттай байхаар зарласан талбайг;

means an area that the Director has declared to be a security enhanced area under the Act:

Агууламжийн мэдэгдэл /Statement of content гэж агаараар тээвэрлэх ачаа, эсхүл шуудангаар илгээх бараанд агуулагдаж буй эд зүйлийн үнэн зөв тодорхойлолтыг;

means an accurate description of the items that are contained within a consignment of cargo or mail for carriage by air:

Аяллын түлш /Trip fuel гэж хөөрөлтийн гүйлт эхлэхээс, ХБЗ-аас гарахын өмнө буултын гүйлт дуусах хүртэл тухайн төлөвлөсөн нислэгт шаардлагатай түлшийг;

means the fuel required for the planned flight from the commencement of the take off run to the completion of landing run prior to runway turnoff:

Хараа /Visibility гэж агаар мандлын нөхцлөөр тодорхойлогддог, хэмжих нэгжээр илэрхийлдэг, гэрэлтүүлэггүй биетийг өдрөөр, гэрэлтүүлэгтэй биетийг шөнөөр харах болон таних чадварыг;

means the ability, as determined by atmospheric conditions and expressed in units of measurement, to see and identify prominent unlighted objects by day and prominent lighted objects by night:

Бүртгэгч улс /State of Registry гэж тухайн агаарын хөлгийг бүртгэлдээ авсан улсыг;

means the state on whose register the aircraft is entered:

Багийн гишүүн /Crew member гэж агаарын хөлгөөр тээвэрлэж буй дараах этгээдийг:

(1) тухайн үйл ажиллагаа эрхлэгчээр томилогдсон—

(i) тухайн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой үүрэг гүйцэтгэх нисэх багийн гишүүн, эсхүл бүхээгийн ажилтан; эсхүл

(ii) нислэгийн хугацаанд тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой үүрэг гүйцэтгэх; эсхүл

(2) зөвхөн дараах зорилгоор тээвэрлэж буй—

(i) тухайн агаарын хөлгийн нислэгийн болон навигацийн зааварчилгаа авч, эсхүл өгч байгаа; эсхүл

(ii) нисэх-инженерийн, эсхүл бүхээгийн ажилтны зааварчилгаа авч байгаа; эсхүл

(3) нислэгийн хугацаанд тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой үүрэг гүйцэтгэхээр Даргын зөвшөөрсөн; эсхүл

(4) нислэгийн шалгагч;

means a person carried by an aircraft who is—

(1) assigned by the operator—

(i) as a flight crew member or flight attendant to perform a duty associated with the operation of the flight; or

(ii) to perform a duty associated with the operation of the aircraft during flight time; or

(2) carried for the sole purpose of—

(i) undergoing or giving instruction in the control and navigation of the aircraft; or

(ii) undergoing instruction as a flight engineer or flight attendant; or

(3) authorised by the Director to exercise a function associated with the operation of the aircraft during flight time; or

(4) a flight examiner:

Багийн нэмэлт гишүүн /Augmented crew гэж тухайн онгоцны гэрчилгээжүүлэлтээр шаардсан минимум багийн гишүүдээс илүү бүрдүүлсэн, онгоцонд байгаа багийн гишүүнийг;

means the crew on an aeroplane when it is comprised of more than the minimum crew required by the aeroplane certification:

Баримт бичиг / Document гэж дараах аливаа хэлбэрийн баримт бичгийг:

(1) аливаа материал дээр бичигдсэн аливаа бичиг/бичигдсэн зүйл;

(2) аливаа бичлэгийн төхөөрөмж, компьютер, эсхүл бусад төхөөрөмжид бичигдсэн, эсхүл хадгалагдсан аливаа мэдээллүүд болон бичигдсэн, эсхүл хадгалагдсан мэдээллээс дараа нь гаргаж авсан аливаа материал;

(3) аливаа ном, газрын зураг, схем зураг, төлөвлөгөө, диаграм, эсхүл зураг;

(4) аливаа фото зураг, хальс, негатив, хуурцаг, эсхүл нэг, эсхүл хэд хэдэн дүрсийг агуулсан (бусад төхөөрөмжийн тусламжтай, эсхүл тусламжгүйгээр) сэргээх чадвартай бусад хэрэгслийг;

means a document in any form, and includes—

(1) any writing on any material:

(2) any information recorded or stored by means of any tape recorder, computer, or other device; and any material subsequently derived from information so recorded or stored:

(3) any book, map, chart, plan, graph, or drawing:

(4) any photograph, film, negative, tape, or other device in which one or more visual images are embodied so as to be capable (with or without the aid of some other equipment) of being reproduced:

Бохирдсон / Contaminated гэж ХБЗ-ны хувьд, тухайн шаардлагатай ХБЗ-ны урт болон өргөн дотор, тухайн талбайн гадаргуугийн 25-аас дээш хувь нь ус, шавар шалбааг, эсхүл 3 мм-ээс дээш зузаантай зөөлөн цасаар хучигдсан, эсхүл ХБЗ-ны гадаргуугийн талбайн аливаа хэсэг мөстэй бол;

in relation to a runway, means more than 25% of the runway surface area within the required length and width is covered by surface water, slush, or loose snow more than 3 millimetres in depth, or ice on any part of the runway surface area:

Тохиромжтой аэродром / Adequate aerodrome гэж тухайн ашиглаж буй онгоцны хувьд ИНД-121.71-д заасан аэродромын болон ХБЗ-ны тухайн холбогдох шаардлагыг хангасан байхаас гадна, хэрэв тухайн аэродром нь замын нөөц аэродромоор тогтоогдсон бол зэрэглэл 4-өөс доошгүй авран хамгаалах, гал унтраах тоноглолыг онгоц ирэх тооцоот цагаас 30 минутын өмнө урьдчилан мэдэгдсэн тохиолдолд, бэлэн байлгах ёстой аэродромыг;

means an aerodrome where the applicable requirements for the aerodrome and runway prescribed in rule 121.71 are met for the particular aeroplane being operated except that, if the aerodrome is designated as an en-route alternate aerodrome the rescue and fire fighting equipment must be at least category 4 and must be available, with at least 30 minutes prior notification, at the expected time of arrival of the aeroplane:

Бөмбөлөг / Balloon гэж хүчний төхөөрөмжөөр хөтлөгдөж хөдөлдөггүй, агаараас хөнгөн агаарын хөлгийг;

means a non-power-driven lighter-than-air aircraft:

Бүсийн удирдлагын төв / Area control centre гэж өөрийн хариуцлагын бүсэд, хяналттай нислэгт НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдсан нэгжийг;

means a unit established to provide ATC service to controlled flights in control areas under its jurisdiction:

Бүсийн удирдлагын үйлчилгээ / Area control service гэж хяналттай агаарын зайд, хяналттай нислэгт үзүүлж буй НХУ-ын үйлчилгээг;

means an air traffic control service provided for controlled flights in controlled airspace

Бүсийн навигаци / Area Navigation гэж газарт, эсхүл сансарт байрласан навигацийн системүүдийн үйлчлэлийн бүсийн хүрээнд, эсхүл өөртөө агуулсан навигацийн тоног төхөөрөмжийн чадамжийн хязгаарлалтын хүрээнд, эсхүл эдгээр нь хамтран агаарын хөлөгт аливаа сонгосон нислэгийн замаар үйл ажиллагаа явуулах боломжийг олгодог навигацийн аргачлалыг;

means a method of navigation which permits aircraft operation on any desired flight path within the coverage of ground or space-based navigation systems or within the limits of the capability of self-contained navigation systems, or a combination of these:

Бүрдэл хэсэг / Component гэж нислэгийн үед агаарын хөлгийг ажиллуулах, эсхүл удирдахад ашигладаг, эсхүл ашиглахаар зорьж буй, эсхүл тухайн агаарын хөлөгт суурилагдсан, эсхүл бэхлэгдсэн, тухайн үйлдвэрлэгч эдгээр зүйлсийг стандарт эд анги гэж тооцсоноос бусад тохиолдолд, тухайн үйлдвэрлэгчээс олгосон серийн

болон эд ангийн дугаартай, их бие, агаарын хөлгийн хөдөлгүүр, эсхүл сэнсийг багтаасан аливаа багаж хэрэгсэл, механизм, тоног төхөөрөмж, эд анги, эсхүл туслах тоноглолыг;

means any instrument, mechanism, equipment, part, or accessory, including an airframe, aircraft engine, or propeller, that is used, or is intended to be used, in operating or controlling an aircraft in flight, or is installed in or attached to the aircraft, that has a part number or a serial number allocated by the manufacturer, unless the manufacturer has designated such an item as a standard part

Бүрэн ажиллагаатай хос удирдлага / Fully functioning dual controls гэж босоо, хөндлөн, хэвтээ болон хөдөлгүүрийн чадлын удирдлагыг нисгэгчийн байр бүрээс удирддаг байхыг;

means pitch, roll, yaw, and engine power controls which can be operated from each pilot station:

Бүхээгийн ажилтан / Flight attendant гэж Үйл ажиллагаа эрхлэгчээс, агаарын хөлөгт зорчигчдын аюулгүй байдыг тухайн хөлгийн даргын өмнө хариуцахаар томилогдсон, зохих журмын дагуу сургалтад хамрагдсан этгээдийг;

means an appropriately trained person assigned by the operator to be responsible to the pilot-in-command for passenger safety on an aircraft:

Бэлтгэл аэродром / Alternate aerodrome гэж буухаар зорьсон тухайн аэродромыг чиглэн нисэх, эсхүл буух боломжгүй болох, эсхүл нисэх, эсхүл буухыг зөвлөөгүй үед агаарын хөлөг чиглэн нисэж болох аэродромыг;

means an aerodrome to which an aircraft may proceed when it becomes either impossible or inadvisable to proceed to or land at the aerodrome of intended landing:

Буултын боломжит зай / Landing distance available (LDA) гэж онгоцны газрын гүйлтэд бэлэн бөгөөд тохиромжтой гэж тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгчээс мэдэгдсэн ХБЗ-ны уртыг;

means the length of the runway that is declared by the aerodrome operator as available and suitable for the ground run of an aeroplane:

Хувийн байрлал дохиологч маяк / Personal locator beacon гэж эрэн хайх, авран туслах үйл ажиллагаанд туслах зорилгоор, тусгайлсан дохиог тогтоогдсон давтамжаар мэдээлэх, хувь хүн биедээ авч явахаар бүтээгдсэн, гараар идэвхжүүлдэг төхөөрөмжийг;

means an equipment that broadcasts a distinctive signal on a designated radio frequency to facilitate a search and rescue operation, is designed to be carried on a person, and is manually activated:

Бөглүү/ алслагдсан / хязгаарлагдмал аэродром / Remote aerodrome гэж хөөрөлт, эсхүл буултад ашиглагддаг, ус, эсхүл газар дээрх, дараах аливаа талбай, эсхүл байгууламжийг:

(1) замаар, эсхүл усаар нэвтрэхэд хязгаарлагдсан, хязгаарлагдмал, эсхүл газарзүйн нөхцөлөөр хаагдсан;

(2) ИНД-139-ийн дагуу Даргын хүлээн зөвшөөрөхүйц аэродромын стандартыг хангаагүй;

means any structure or any area of land or water used for take-off or landing—

- (1) to which access by road or water is restricted, limited or obstructed by geographical conditions; and
- (2) that does not meet standards for aerodromes that are acceptable to the Director under Part 139:

В ангиллын ачааны, эсхүл тээшний бүхээг / Class B cargo or baggage compartment гэж дараах ачааны, эсхүл тээшний хэсгийг:

- (1) нислэгт, багийн гишүүн чөлөөтэй нэвтрэх гарц бүхий, гар гал унтраагууртай бүхээгийн аль ч хэсэгт саадгүй хүрэх боломжтой;
- (2) нэвтрэх гарцыг ашигласан үед багийн гишүүд, эсхүл зорчигч байрласан аливаа бүхээгт осолтой хэмжээний утаа, гал, эсхүл унтраах бодис нэвтэрч ордоггүй;
- (3) нисгэгч, эсхүл нисэх-инженерийн ажлын байранд анхааруулах дохио өгөх, тусдаа, зөвшөөрөгдсөн гал, эсхүл утаа илрүүлэгч системтэй;

means a cargo or baggage compartment in which—

(1) there is sufficient access in flight to enable a crew member to effectively reach any part of the compartment with the contents of a hand fire extinguisher; and

(2) when the access provisions are being used, no hazardous quantity of smoke, flames, or extinguishing agent, will enter any compartment occupied by the crew or passengers; and

(3) there is a separate approved smoke detector or fire detector system to give warning at the pilot or flight engineer station:

Вариант / Variant гэж онгоцны нэг үндсэн маяг, эсхүл мастер сериэс гаралтай боловч тоног төхөөрөмж нь ялгаатай, эсхүл аюулгүй үйл ажиллагааны журам нь нисэх багийн гишүүдээс нэмэлт мэдлэг, ур чадвар, эсхүл чадавхи шаарддаг онгоцыг;

means an aeroplane which is a derivative of a base aeroplane type or master series, but has differences in equipment or procedures which require additional flight crew knowledge, skills, or abilities for safe operation:

Гар тээш /Carry on baggage гэж тээш болон дараах аливаа бусад эд зүйлийг:

- (1) тухайн Үйл ажиллагаа эрхлэгчтэй байгуулсан гэрээний дагуу зорчигч, эсхүл багийн гишүүд агаарын хөлөгт авч ордог;
- (2) тухайн зорчигч, эсхүл багийн гишүүний хяналтад байдаг;

means baggage and any other item that—

(1) is carried on to an aircraft by a passenger or crew member with the agreement of the operator; and

(2) remains in the custody of the passenger or crew member

Гадаадын агаарын хөлөг / Foreign aircraft гэж дараах агаарын хөлгийг:

- (1) ИНД-47-ийн дагуу бүртгэгдсэн байхыг шаардсан; болон
- (2) Монгол Улсад бүртгэгдээгүй агаарын хөлөг;

means an aircraft that—

- (1) is required under Part 47 to be registered; and
- (2) is not a Mongolian registered aircraft:

Ганц нисгэгчтэй үйл ажиллагаанд гэрчилгээжсэн / Certificated for single pilot operation гэж агаарын хөлгийн хувьд, гэрчилгээжүүлэлтийн явцад Бүртгэгч улсаас минимум багийн гишүүн нь нэг нисгэгчтэй аюулгүй ажиллаж чадах агаарын хөлгийн маяг болохыг тогтоосныг;

in relation to an aircraft means determined by the State of Registry, during the certification process, to be a type of aircraft that can be operated safely with a minimum crew of one pilot:

Ганц хөдөлгүүрт ХНД-ийн зорчигчийн үйл ажиллагаа / SEIFR passenger operation гэж ганц хөдөлгүүрт онгоцоор, ХНД / IFR-ийн дагуу зорчигч тээвэрлэх агаарын тээврийн үйл ажиллагааг;

means an air transport operation carrying passengers in a single-engine aeroplane under IFR:

Ганц нисгэгчтэй агаарын хөлөг / Single-pilot aircraft гэж тухайн нислэгийн төрөлд, минимум нисэх баг нь нэг нисгэгчтэйгээр үйл ажиллагаа эрхлэхээр Нислэгийн зааварт нь зөвшөөрөгдсөн агаарын хөлгийг;

means an aircraft that is authorised in its flight manual to be operated with a minimum flight crew of 1 pilot for the type of flight:

Галт зэвсэг / Firearm гэж 2015 оны Галт зэвсгийн тухай хуульд зааснаар ойлгоно; has the same meaning as the Firearm Act 2015:

Газар тариалангийн химийн бодис /Agricultural chemical гэж дараах зориулалттай аливаа бодисууд, эсхүл бодисуудын хольцыг:

- (1) холбогдох эрх бүхий байгууллагаас улсын, эсхүл орон нутгийн хэмжээнд хөдөө аж ахуйн хортон шавьж, эсхүл хортой ургамал гэж зарласан аливаа хорхой шавьж, мэрэгч амьтад, хялгасан хорхой, хогийн ургамал, мөөгөнцөр, эсхүл бусад амьтан, ургамлын бусад хэлбэрүүд, эсхүл вирус /хүн, эсхүл амьтны биед байдаг вирусээс бусад/-ээс хамгаалах, устгах, үргээх, эсхүл багасгах; эсхүл
- (2) ургамлын ургалтыг зохицуулагч, устгагч, эсхүл хатаагчаар ашиглах;

means any substance or mixture of substances intended for—

- (1) preventing, destroying, repelling, or mitigating any insects, rodents, nematodes, fungi, weeds or other forms of plant, animal life or viruses (except viruses on or in living man or other animals) which have been declared by the appropriate authority to be a national or regional pest or noxious plant; or
- (2) use as a plant regulator, defoliant or desiccant:

Гэрчилгээжсэн байгууллага /Certificated organization гэж Хуулийн дагуу боловсруулсан дүрмийн дагуу гэрчилгээ олгогдсон байгууллагыг;

means an organisation issued with a certificate under rules made under the Act

Газарзүйн солбицол /Geographical co-ordinates гэж Дэлхийн Геодезийн систем (1984)-ийн газар зүйн тогтоогдсон өгөгдлөөр илэрхийлэгдэх өргөрөг болон уртрагийг;

mean latitude and longitude that are expressed relative to the geodetic reference datum of the World Geodetic System 1984:/

Глайдер /Glider гэж:

(1) нислэгийн тодорхой нөхцөлд хөдөлгөөнгүй байрласан гадаргуу нь агаартай харилцан үйлчилснээр, нислэгт үндсэн өргөх хүч үүсгэдэг, хөтлөгч хүчний төхөөрөмжгүй, агаараас хүнд агаарын хөлгийг;

(2) үүнд, хөдөлгүүр нь ажиллаж байгаа эсэхээс үл хамааран моторт глайдер мөн багтана;

(1) means a non-power-driven heavier-than-air aircraft that derives its lift in flight chiefly from aerodynamic reactions on surfaces which remain fixed under given conditions of flight; and

(2) includes a powered glider whether the engines are operating or not:

Глайдерын байгууллага /Gliding organisation гэж глайдерын үйл ажиллагаатай холбоотой тусгай эрх хэрэгжүүлэх эрх олгогдсон, ИНД-149-ийн дагуу Нисэх клубын гэрчилгээ эзэмшигчийг;

means the holder of an aviation recreation organisation certificate issued in accordance with Part 149 that authorises specified privileges associated with the operation of gliders:

Гурван талын зураг /Three-view drawing гэж агаарын хөлгийн харагдах байдлыг дээд, урд болон хажуугийн түвшингээс цогцоор харуулсан, агаарын хөлгийн нарийвчилсан дүрслэлийг;

means, the accurate depiction of an aircraft from a collection of views that includes a plan, a front elevation, and a side elevation:

Дарга /Director гэж хуулийн дагуу томилогдсон Иргэний нисэхийн ерөнхий газрын даргыг;

means the person who is for the time being the Director of Civil Aviation under the Act

Даргын дадлага /Command practice гэж Үйл ажиллагаа эрхлэгчээс, тухайн зорилгоор томилсон хөлгийн даргын хяналтан дор, нислэгийн турш хөлгийн даргын ажил, үүргийг гүйцэтгэх хамтран нисгэгчийн гүйцэтгэлийг;

means the performance by a co-pilot of the duties and functions of a pilot-in-command during a flight under the supervision of a pilot-in-command designated for the purpose by the operator.

Даялалтын максимум хугацаа /Maximum diversion time гэж EDTO нислэг үйлдэж байгаа тухайн цэгээс, замын EDTO бэлтгэл аэродром хүрэх олон турбин хөдөлгүүрт онгоцны, стандарт агаар мандал /ISA/-ын нөхцөлд, тогтуун агаарт, нэг хөдөлгүүр татгалзсан аяллын хурдтай нисэхээр тооцсон максимум нислэгийн цагийг

means the maximum flight time, calculated at a one-engine inoperative cruise speed in still air and ISA conditions, that a multi-engine turbine powered aeroplane operating on an EDTO may be from an en-route EDTO alternate aerodrome;

Даялалтын хугацааг сунгасан нислэгийн үйл ажиллагаа /Extended diversion time operation (EDTO) гэж олон турбин хөдөлгүүрт онгоцны замын тухайн цэгээс бэлтгэл аэродромд нисэн хүрэхээр тооцсон нислэгийн цаг нь (стандарт агаар мандал /ISA/-ын нөхцөлд, тогтуун агаарт, нэг хөдөлгүүр татгалзсан аяллын хурдтайгаар тооцсон) тухайн онгоцонд тогтоогдсон цагаас их байх нислэгийг;

means a flight by a multi-engine turbine powered aeroplane where the flight time (calculated at a one engine inoperative cruise speed in still air and ISA conditions) from a point on the route to an adequate aerodrome is greater than the threshold time for the aeroplane:

Даралтын түвшин /Pressure altitude гэж тухайн стандарт агаар мандлын даралттай харьцуулсан, түвшний утгаар илэрхийлсэн агаар мандлын даралтыг;

means an atmospheric pressure, expressed in terms of altitude, which corresponds to that pressure in the standard atmosphere;

Дамжин өнгөрөх тээш /Transit baggage гэж:

- (1) аэродромд агаарын хөлөг ирэхэд түүний бүхээгт байсан; ба
- (2) агаарын хөлөг, тухайн аэродромыг орхиход түүний бүхээгт үлдсэн тээшийг;

means baggage that—

- (1) is on board an aircraft that arrives at an aerodrome; and
- (2) is still on board that aircraft when that aircraft leaves the aerodrome:

Дутагдал /Defect гэж нисэхийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүн, эсхүл эд ангийн чанар, эсхүл бүтцэд өөрчлөлт орсноор зориулалтынхаа шаардлагыг хангахгүй болж, нислэгт тэнцэх чадвараа алдахыг;

means a change in the state or quality of an aeronautical product, a product, or a component that makes it unfit for its intended purpose and not in an airworthy condition

Ханг-глайдер /Hang glider гэж аливаа хүчний төхөөрөмжийн тусламжгүйгээр, агаартай харилцан үйлчилж, агаарын урсгалын нөлөөллөөр агаарт дүүжлэгдэн, хөдөлгөөн үйлдэх агаараас хүнд нисэх төхөөрөмжийг;

means a glider, including a powered glider, that is capable of being launched and landed solely by the use of the pilot's legs, and includes paragliders:

Ханг-глайдерын үйл ажиллагаа эрхлэгч байгууллага /Hang gliding organisation гэж ханг-глайдерын үйл ажиллагаатай холбоотой тусгай эрхийг хэрэгжүүлэх эрх олгогдсон, ИНД-149-ийн дагуу Нисэх клубын гэрчилгээ эзэмшигчийг;

means the holder of an aviation recreation organisation certificate issued in accordance with Part 149 that authorises specified privileges associated with the operation of hang gliders:

Дирижабль /Airship гэж хүчний төхөөрөмжийн тусламжтайгаар хөдөлдөг, агаараас хөнгөн агаарын хөлгийг;

means a power-driven lighter-than-air aircraft:

Дагалдагчтай /хамгаалалттай зорчигч /Escorted passenger гэж агаарын тээврийн үйл ажиллагааны турш, томилогдсон эскортын оролцоог шаарддаг аливаа зорчигчийг;

means any passenger requiring the personal attendance of an appointed escort, during an air transport operation:

Ерөнхий нисэхийн агаарын зай /General aviation area гэж, ИХНД/VFR-ийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж болох, G ангиллын агаарын зайн дүрмүүдэд хамаарах тодорхойлсон хэмжээтэй агаарын зайг;

means an airspace, of defined dimensions, in which intensive VFR activity may occur and the rules of Class G airspace apply:

Ерөнхий чиглэл /General direction гэж ИНД-67-ийн хувьд, Даргын гаргасан Ерөнхий чиглэлийг;

in relation to Part 67 means a general direction issued by the Director:

Засвар /Repair гэж бүтээгдэхүүн, бүрдэл хэсэг, эсхүл хэрэгслийг түүний үндсэн эх, эсхүл зөв сайжруулсан конфигурацид буцаан оруулах зорилго бүхий загварын өөрчлөлтийг;

a design change that is intended to return the product, component, or appliance to its original, or properly modified configuration:

Зардал хуваах нислэг / Cost sharing flight гэж зөвхөн хүмүүс тээвэрлэхээр гүйцэтгэсэн дараах аливаа нислэгийг:

- (1) тухайн нислэгийг нийтэд зарлан сурталчлаагүй;
- (2) тухайн багийн гишүүд нь үйлчилгээндээ ямар нэг төлбөр, эсхүл урамшуулал авдаггүй;
- (3) тухайн агаарын хөлгөөр тээвэрлэгдсэн хүмүүс болон багийн гишүүд тухайн нислэгийн зардлыг адил тэнцүү хуваадаг;
- (4) тухайн нислэгт оролцсон этгээдээс энэ хэсгийн (3)-т зааснаас өөр төлбөр, эсхүл урамшуулал шаарддаггүй;

Зардал хуваах нислэг нь төлбөртэй үйл ажиллагаа биш.

means any flight that is performed solely for the carriage of persons where—

- (1) the flight is not advertised to the public; and
- (2) the crew members receive no payment or other reward for their services; and
- (3) the persons carried by the aircraft, including the crew members, share equally in the cost of the flight; and
- (4) no payment or other reward is required of a person on the flight other than that specified in subparagraph (3)—

and, for the avoidance of doubt, a cost sharing flight is not an operation for hire or reward:

Зарлагдсан зай /Declared distance гэж ХБЗ-ны хувьд дараах аливаа зайг:

Хөөрөлтийн гүйлтийн боломжит зай (TORA);

Хөөрөлтийн боломжит зай (TODA);

Хурдатгалтай зогсох боломжит зай (ASDA);

Буултын боломжит зай (LDA);

in relation to a runway means any of the following—

take-off run available:

take-off distance available:

accelerate-stop distance available:

landing distance available

Замын/нислэгийн ачаалал /Traffic load гэж зорчигч, тээш болон ачааны нийт жинг;

means the total weight of passengers, baggage, and cargo:

Загварын өөрчлөлт /Design change гэж хэрэв, маягийн загварын өөрчлөлт, эсхүл маягийн гэрчилгээ, эсхүл маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний аливаа бусад хэсэгт хийгдсэн өөрчлөлт нь бүтээгдэхүүн, түүний бүрдэл хэсэг, эсхүл хэрэгсэлд модификаци, эсхүл засвар хийхийг шаарддаг бол;

means a change to a type design or a change to any other part of a type certificate or type acceptance certificate that if incorporated would require the modification or repair of a product, its components, or an appliance:

Зөрчил /Incident гэж, агаарын хөлгийн үйл байдалтай холбоотой, агаарын хөлгийн аюулгүй үйл ажиллагаанд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болох, ослоос бусад аливаа хэрэг явдлыг;

means any occurrence, other than an accident, that is associated with the operation of an aircraft and affects or could affect the safety of operation:

Зөвшөөрлийн хязгаар /Clearance limit гэж агаарын хөлөг нисэн хүрэх, НХУ-аас зөвшөөрөл олгосон тухайн цэгийг;

means the point to which an aircraft is granted an ATC clearance

Зөвшөөрөгдсөн /Approved гэж бусад этгээдтэй холбоотой хэрэглэгдэж байгаагаас бусад тохиолдолд, Даргаар бичгээр зөвшөөрөгдсөн;

unless used with reference to another person, means approved in writing by the Director:

Зөвшөөрөгдсөн сургалт /Approved training гэж Хэлэлцэн тохирогч улсын зөвшөөрсөн тусгай хөтөлбөр болон хяналтын дор хийгдсэн сургалтыг, хувь хүний үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн хувьд, зөвшөөрөгдсөн сургалтын байгууллагаар зохион байгуулагдсан сургалтыг;

means training conducted under special curricula and supervision approved by a Contracting State that, in the case of PEL, is conducted within an approved training organisation:

Зорчигч /Passenger гэж агаарын хөлгөөр тээвэрлэж буй багийн гишүүдээс бусад аливаа этгээдийг;

means any person carried by the aircraft, other than a crew member:

Зорчигч тээврийн тогтмол нислэгийн үйлчилгээ /Regular air transport passenger service гэж Үйл ажиллагаа эрхлэгч аливаа дараалсан 28 хоногийн дотор, хоёр, эсхүл хэд хэдэн аэродромын хооронд 4, эсхүл түүнээс дээш удаа агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхийг;

a service offered by an operator consisting of four or more air transport operations for the carriage of passengers between two or more aerodromes within any consecutive 28 day period:

Зохион бүтээгчийн харъяалах улс /State of Design гэж тухайн маягийн загварыг хууль ёсоор хариуцсан байгууллагыг харъяалах улсыг, эсхүл хэд хэдэн улсын байгуулсан байгууллагыг;

means the State, or an organisation established by a group of States, having jurisdiction over the organisation responsible for the type design:

Зогсоох зурвас /Stopway гэж хөөрөлтийг үргэлжлүүлэх боломжгүй үед агаарын хөлгийг зогсоох зорилгоор гүйлтийн боломжит замын төгсгөлд бэлдсэн, газар дээр тогтоосон, тохиромжтой тэгш өнцөгт талбайг;

means a defined rectangular area on the ground at the end of the take-off run available prepared as a suitable area on which an aircraft can be stopped in the case of an abandoned take-off:

Зэрэглэл /Rating гэж үнэмлэх, эсхүл гэрчилгээнд хамааралтай тусгай нөхцөл, эрх, эсхүл хязгаарлалт тогтоож байгаа, үнэмлэх, гэрчилгээ, эсхүл бүртгэлийн дэвтэрт тэмдэглэгдэх, эсхүл хавсаргагдах эрхийг;

means an authorisation entered on, or associated with, a licence, certificate, or logbook, and forming part of it, stating special conditions, privileges, or limitations relating to the licence or certificate:

ZFT дадлагажуур / ZFT simulator гэж:

(1) FAR Part12, Appendix H-д заасан D/ phase III түвшний шаардлагад нийцсэн; эсхүл

(2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх стандартад нийцсэн;

means a synthetic flight trainer which—

(1) meets the standard of level D/phase III as described in Appendix H (dated 30 July 1980) to Part 121 of the United States Federal Aviation Regulations; or

(2) meets an equivalent standard acceptable to the Director.

Ил харааны нислэгийн цаг уурын нөхцөл /Visual meteorological conditions гэж тогтоогдсон хязгаарлалттай тэнцүү ба түүнээс дээш, алсын барааны харагдац, үүл хүртэлх зай ба үүлний доод суурийн өндрөөр илэрхийлэгдэх цаг уурын нөхцөлийг;

means meteorological conditions expressed in terms of visibility, distance from cloud, and ceiling equal to or better than specified minima:

Илтгэх цэг /Reporting point гэж агаарын хөлөг байрлалаа харьцуулан илтгэж болох заагдсан (нэрлэгдсэн) газар зүйн байршлыг;

a specified (named) geographical location in relation to which the position of an aircraft can be reported:

ИХНД-ийн нислэг /VFR flight гэж Ил харааны нислэгийн дүрмийн дагуу үйлдэж байгаа нислэгийг;

means a flight conducted in accordance with the visual flight rules

Иргэний нисэхийн дүрмүүд /Civil Aviation Rules гэж Иргэний нисэхийн хуулийн дагуу боловсруулсан дүрмүүдийг;

means rules made under the Act:

Итгэмжлэгдсэн эмчийн дүгнэлт /Accredited medical conclusion гэж эрүүл мэндийн гэрчилгээ хүсэж өргөдөл гаргагчийн эрүүл мэндийн талаар тухайн тохиолдолд Даргаас итгэмжлэгдсэн нэг, эсхүл хэд хэдэн эксперт эмчийн гаргасан дүгнэлтийг;

means the conclusion reached, regarding the medical fitness of an applicant for a medical certificate, by one or more medical experts acceptable to the Director for the purposes of the case concerned:

Их засвар /Overhaul гэж агаарын хөлөг, эсхүл агаарын хөлгийн бүрдэл хэсгийн хувьд, задаргаа, үзүүлэлтийг бататгах бүрэн тест болон ашиглалтын хугацааг сэргээх ажил оролцсон их хэмжээний ажил, үйл ажиллагаа гүйцэтгэхийг;

in relation to an aircraft or aircraft component, means to perform a major work operation which involves dismantling and complete testing to specification and renewal of operational life:

ИКАО-ийн Хавсралт /ICAO Annex гэж Конвенцийн Хавсралтууд болон дүрэмд өөрөөр заагаагүй бол Иргэний нисэхийн тухай хуулийн дагуу хүчинтэй өөрчлөлтүүд багтана, гэхдээ Монгол Улс мэдэгдсэн зөрүүтэй Хавсралтууд багтахгүй.

means an Annex to the Convention and unless otherwise specified in a rule, includes the amendments in force under the Act, but excludes any differences to an Annex as notified by Mongolia:

ИКАО-ийн Хэлэлцэн тохирогч улс /ICAO Contracting State гэж Конвенцид гарын үсэг зурсан улсыг ойлгох бөгөөд үүнд Конвенцид гарын үсэг зурсан хэд хэдэн улсын байгуулсан, эдгээр улсуудын өмнөөс нисэхийн холбогдолтой баримт бичиг, эсхүл эрх олгодог байгууллага мөн багтана;

means a State that is a signatory to the Convention; and includes an organisation established by a group of States that are signatories to the Convention to issue an aviation related document or authorisation on behalf of those States:

EDTO нөөц аэродром /EDTO alternate aerodrome гэж дараах бэлтгэл аэродромыг:

- (1) ИНД-139-ийн дагуу гэрчилгээжсэн, эсхүл гэрчилгээжсэн аэродромд тавигддаг аюулгүй байдлын дүйцэх шаардлагыг хангасан;
- (2) Ашиглаж буй онгоцны маягт нийцсэн үйлчилгээ болон тоног төхөөрөмж, мөн дараах үйлчилгээ үзүүлдэг:
 - (i) тухайн аэродромын цаг уурын урьдчилсан мэдээ;
 - (ii) тухайн улсын AIP-д хэвлэгдсэн, хэрэглэлээр ойртолт үйлдэх 1-ээс доошгүй тохирсон журам;
 - (iii) онгоц нисэн ирэх тооцоот цагаас 30 минутын өмнө урьдчилан мэдэгдсэн тохиолдолд аэродромын хяналтын үйлчилгээ, эсхүл аэродромын нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх чадвартай;
 - (iv) онгоц нисэн ирэх тооцоот цагаас 30 минутын өмнө урьдчилан мэдэгдсэн тохиолдолд 4-өөс доошгүй зэрэглэлийн гал унтраах, авран хамгаалах тоног төхөөрөмжөөр үйлчлэх чадвартай;

means an adequate aerodrome that—

- (1) is certificated under Part 139 or meets safety requirements equivalent to such an aerodrome; and
- (2) provides services and facilities for the aeroplane type being used including—
 - (i) meteorological forecasts for the aerodrome; and
 - (ii) at least 1 suitable instrument approach procedure that is published in the AIP of the State concerned; and
 - (iii) an aerodrome control service or aerodrome flight information service that can be provided from at least 30 minutes before the estimated time of arrival of the aeroplane; and
 - (iv) rescue and fire fighting equipment to at least category 4 that can be provided, with at least 30 minutes prior notification, at the estimated time of arrival of the aeroplane;

EDTO эхлэх цэг / EDTO entry point гэж тухайн цэгээс стандарт агаар /ISA/-ын нөхцөлд, тогтуун агаарт, нэг хөдөлгүүр татгалзсан аяллын хурдтайгаар бэлтгэл аэродромд нисэн хүрэхээр тооцсон нислэгийн цаг нь тухайн онгоцонд тогтоогдсон цагаас их байх, EDTO нислэгийн зам дээрх анхны цэгийг;

means the first point on a route flown by an aeroplane on an EDTO where the flight time from that point to an adequate aerodrome, calculated at a one engine inoperative cruise speed in still air and ISA conditions, exceeds the threshold time for the aeroplane:

EDTO онцгой чухал систем /EDTO significant system гэж EDTO-ийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх онгоцны татах хүчний систем болон онгоцны аливаа бусад системийн татгалзал, эсхүл EDTO-г аюулгүй үргэлжлүүлэн хадгалах болон чиглэлээ өөрчлөн аюулгүй буулт үйлдэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг системүүдийг; means the aeroplane propulsion system and any other aeroplane system whose failure could adversely affect the safety of an EDTO, or whose functioning is important to the continuing safety of an EDTO and to a safe landing during a diversion:

EDTO баталгаажуулах нислэг /EDTO verification flight гэж EDTO-ийн үйл ажиллагаанд тухайн онгоцны бэлэн байдлыг тогтоох зорилгоор үйлдэх нислэгийг;

means a flight conducted to establish that the aeroplane is serviceable for an EDTO:

Конфигураци /Configuration гэж агаарын хөлгийн хувьд, далавчны флапс, эсхүл газардах анги зэрэг онгоцны аэродинамик үзүүлэлтүүдэд нөлөөлөх хөдөлгөөнт элементүүдийн байрлалын тодорхой өөрчлөлтийг;

in relation to an aircraft, means a particular combination of the positions of the movable elements, such as wing flaps or landing gear, which affect the aerodynamic characteristics of the aeroplane

Конфигураци, техник үйлчилгээ болон үйл ажиллагааны стандарт баримт бичиг /Configuration, maintenance and procedures standards document гэж EDTO-ийн шаардлагад нийцүүлэн онгоцны конфигурацийн минимум шаардлагыг тогтоосон, аливаа тусгай үзлэг, эд ангийн ашиглалтын хязгаарлалт, нисэх багийн журам, MMEL-ийн хязгаарлалтууд болон онгоцны их бие/ хөдөлгүүрийн хослолын харилцан ажиллагааны тохиромжтой байдлыг тогтооход зайлшгүй шаардлагатай техник үйлчилгээний практик аргачлалыг багтаасан, онгоцыг гэрчилгээжүүлэх эрх бүхий этгээдээр батлагдсан баримт бичгийг;

means a document approved by the certification authority for the aeroplane specifying the minimum requirements for the aeroplane configuration, including any special inspections, hardware life limits, flight crew procedures, master minimum equipment list constraints, and maintenance practices necessary to establish the suitability of the aeroplane's airframe/engine combination for EDTO:

Конвенци /Convention гэж:

- (1) Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Чикаго хотод гарын үсэг зурсан Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийг; мөн
- (2) дараах зүйлүүдийг багтаасан:
 - (i) Монгол Улс соёрхон баталсан, Конвенцийн Зүйл 94 (а)-д заасны дагуу хүчинтэй болсон Конвенцийн аливаа нэмэлт, өөрчлөлт;
 - (ii) Конвенцийн Зүйл 90-ийн дагуу зөвшөөрөгдсөн аливаа Хавсралт, эсхүл нэмэлт, өөрчлөлт;
 - (iii) Конвенцийн Зүйл 37-д заасны дагуу Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас батлан гаргаж, нэмэлт өөрчлөлт оруулдаг олон улсын стандарт болон зөвлөмж болгож буй практик;

(1) means the Convention on International Civil Aviation signed in Chicago on the 7th day of December 1944; and

(2) includes—

- (i) any amendment to the Convention which has entered into force under Article 94(a) of the Convention and has been ratified by Mongolia; and
- (ii) any Annex or amendment thereto accepted under Article 90 of the Convention; and

(iii) the international standards and recommended practices from time to time accepted and amended by the International Civil Aviation Organisation pursuant to Article 37 of the Convention:

CAT II нарийвчлалтай ойртолт үйлдэх журам /Category II precision approach procedure гэж шийдвэр гаргах өндөр нь 60м (200ft)-ээс доор, гэхдээ 30 (100ft) хөөрч буух зурвасны дагуух алсын барааны харагдац 300м-ээс багагүй үед хэрэглэлээр нарийвчлалтай ойртолт ба буулт үйлдэхийг;

means a precision instrument approach and landing with a decision height lower than 200 feet, but not lower than 100 feet, and a runway visual range not less than 300 m.

CAT III нарийвчлалтай ойртолт үйлдэх журам /Category III precision approach procedure гэж дараах аль нэг хэрэглэлээр үйлдэх нарийвчлалтай ойртолт ба буултыг:

- (1) CAT IIIA: дараах хэрэглэлийн нарийвчлалтай ойртолт болон буултыг—
 - (i) шийдвэр гаргах өндөр 30м (100ft)-ээс доош, эсхүл шийдвэр гаргах өндөр заагаагүй;
 - (ii) хөөрч, буух зурвасны дагуух алсын барааны харагдац 175 м-ээс багагүй;
- (2) CAT IIIB: дараах хэрэглэлийн нарийвчлалтай ойртолт болон буултыг—
 - (i) шийдвэр гаргах өндөр 15м (50ft)-ээс ихгүй, эсхүл шийдвэр гаргах өндөр заагаагүй;
 - (ii) хөөрч, буух зурвасны дагуух алсын барааны харагдац 50 - 175 м;
- (3) CAT IIIC: шийдвэр гаргах өндөр болон алсын барааны харагдацын хязгаарлалтгүй;

means one of the following precision instrument approaches and landings:

- (1) Category IIIA: A precision instrument approach and landing with—
 - (i) a decision height lower than 100 feet (30m) or no decision height; and
 - (ii) a runway visual range not less than 175 m;
- (2) Category IIIB: A precision instrument approach and landing with—
 - (i) a decision height lower than 50 feet (15m) or no decision height; and
 - (ii) a runway visual range less than 175 m but not less than 50 m;
- (3) Category IIIC: A precision instrument approach and landing with no decision height and no runway visual range limitations;

1-р Ангиллын микролайт агаарын хөлөг /Class 1 microlight aircraft гэж 2-р Ангиллын микролайтаас бусад микролайт агаарын хөлгийг;

means a microlight aircraft other than a Class 2 microlight aircraft

2-р Ангиллын микролайт агаарын хөлөг /Class 2 microlight aircraft гэж 2 хүн тээвэрлэхээр зохион бүтээгдэж, тоноглогдсон микролайт агаарын хөлгийг;

means a microlight aircraft designed and equipped to carry 2 persons

3.1A- Ангиллын шатамхай шингэн /Class 3.1A—Flammable liquid гэж дөл үүсэх хэм нь 23°C-аас доош, буцалж эхлэх максимум хэм нь 35°C-аас ихгүй шатамхай шингэн, үүнд бензин суурьтай бүтээгдэхүүнүүд багтана;

means a liquid that has a flash point of below 23°C and has an initial boiling point (IBP) of a maximum 35°C, and includes petrol based products:

3.1C- Ангиллын шатамхай шингэн /Class 3.1C—Flammable liquid гэж дөл үүсгэх хэм нь 23°C, эсхүл түүнээс дээш, гэхдээ 60°C, эсхүл түүнээс доош шатамхай шингэн, үүнд керосин суурьтай бүтээгдэхүүнүүд багтана;

means a liquid that has a flash point at or above 23°C, but at or below 60°C, and includes kerosene based products

3.1D- Ангиллын шатамхай шингэн /Class 3.1D—Flammable liquid гэж дөл үүсэх хэм нь 60°C -аас дээш, гэхдээ 93°C ба түүнээс доош шатамхай шингэн, үүнд дизель бүтээгдэхүүнүүд багтана;

Flash point = дөл үүсэх хэм/ноцох температур

Initial boiling point = буцалж эхлэх хэм

means a liquid that has a flash point of above 60°C, but at or below 93°C, and includes diesel products

1-р Ангиллын үзүүлэлттэй нисдэг тэрэг /Performance Class 1 helicopter гэж эрсдэлтэй хөдөлгүүр татгалзсан тохиолдолд, таслагдсан хөөрөлтийн талбайд буух чадвартай, эсхүл буух боломжтой талбай хүртэл нислэгийг аюулгүй үргэлжлүүлэх техникийн үзүүлэлттэй нисдэг тэргийг;

means a helicopter with performance characteristics such that, in case of critical power-unit failure, it is able to land on the rejected take-off area or safely continue the flight to an appropriate landing area:

Маяг /Type гэж:

- (1) нисэхийн ажилтны үнэмлэхжүүлэлтийн хувьд, нислэгийн үзүүлэлт, эсхүл түүний ашиглалтад нөлөө бүхий өөрчлөлт шаардагаас бусад, бүх модификацыг багтаасан ижил үндсэн загварын бүх агаарын хөлгийг, эсхүл
- (2) агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, эсхүл сэнсний гэрчилгээжүүлэлтийн хувьд, тухайн агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, эсхүл сэнс нь ижил загвартай байхыг;

1/ in relation to the licensing of aviation personnel means all aircraft of the same basic design, including all modifications thereto except those modifications which result in a significant change in handling or flight characteristics;

2/ in relation to the certification of aircraft, aircraft engines, or propellers, means those aircraft, aircraft engines or propellers which are similar in design:

Маневрын талбай / Manoeuvring area гэж:

- (1) агаарын хөлгийн хөөрөлт, буулт болон газар дээрх хөдөлгөөнд ашиглагддаг аэродромын хэсгийг; гэхдээ
- (2) агаарын хөлөгт ачаа ачих, буулгах, эсхүл техник үйлчилгээ хийх зориулалттай талбай орохгүй;

(1) means that part of an aerodrome to be used for the take-off and landing of aircraft and for the surface movement of aircraft associated with take-off and landing; but
(2) does not include areas set aside for loading, unloading, or maintenance of aircraft:

Нисэхийн мэдээллийн эмхэтгэл /Aeronautical Information Publication гэж AIP-ийн үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчээс Иргэний нисэхийн ерөнхий газарт зориулан гаргасан НМЭ-ийг;

means the AIP for Mongolia published for the Authority by the holder of the AIS certificate for the AIP service:

Монгол Улсын Нислэгийн Мэдээллийн Район /Mongolian Flight Information Region гэж:

- (1) Монгол Улсын нутаг дэвсгэрийн хил хязгаараар тогтоогдсон агаарын зай;
- (2) Нислэгийн мэдээллийн бүсийн дээд хязгаар 30.000м (Flight level 999);
- (3) Нислэгийн мэдээллийн бүсийн доод хязгаар нь газрын гадаргуу;

means-

- (1) all that airspace bounded by the Mongolia;
- (2) an upper limit of flight level 999; and
- (3) the surface of the earth as the lower limit.

Мах-тоо /Mach number гэж агаарын бодит хурд болон дууны хурдны харьцааг;
means the ratio of true airspeed to the speed of sound:

Микролайт агаарын хөлөг /Microlight aircraft гэж хоёроос дээшгүй хүн зөөх, Даргын хүлээн зөвшөөрөхуйц бага моментийн өгөгдөхүүнтэй, нислэгийн бага үндсэн үзүүлэлттэй зохион бүтээгдсэн агаарын хөлгийг;

means a basic low performance aircraft designed to carry not more than 2 persons which meets low momentum parameters that are acceptable to the Director:

Микролайтын нисэх клуб /Microlight organisation гэж микролайт агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой эрхийг хэрэгжүүлэх, ИНД-149-ийн дагуу олгогдсон Нисэх клубийн гэрчилгээ эзэмшигчийг;

means the holder of an aviation recreation organisation certificate issued in accordance with Part 149 that authorises specified privileges associated with the operation of microlight aircraft:

Монгол Улсын Агаарын навигацийн бүртгэл /Mongolian Air Navigation Register гэж ИНД-71-ийн дагуу тогтоогдсон Агаарын навигацийн бүртгэлийг;

means the Mongolian Air Navigation Register established under Part 71:

Монгол Улсын Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ /Mongolian Air Operator Certificate (AOC) гэдгийг Иргэний нисэхийн тухай хуульд зааснаар ойлгоно;

Mongolian AOC meaning set out in the Act

Mongolian registered aircraft /Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг гэж тухайн цаг хугацаанд Дарга ИНД-47-ийн дагуу бүртгэсэн аливаа агаарын хөлгийг;

means any aircraft that is for the time being registered by the Director under Part 47:

Mongolian Register of Aircraft /Монгол Улсын агаарын хөлгийн бүртгэл гэж Иргэний нисэхийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн бүртгэлийг;

means the register established under the Act:

Mongolian certificate of registration /Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ гэж Даргын олгосон агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг;

means an aircraft certificate of registration issued by the Director

Нарийвчилсан үзлэг /Detailed inspection гэж хэсэгчилсэн үзлэгийн хувьд, эд анги, эсхүл системийн их засварыг багтаасан, агаарын хөлөг, түүний эд анги, систем болон тоног төхөөрөмжид шаардлагатай түвшин хүртэл задаргаа хийж шалгах үзлэгийг ;

in respect of a progressive inspection, means a thorough examination of an aircraft and its components, systems and equipment with such disassembly as is necessary and includes the overhaul of a component or system:

Нисэхийн өгөгдөл /Aeronautical data гэж нисэхийн хэрэглээнд ашигладаг навигацийн өгөгдөл, terrain болон саадын өгөгдлөөс бүрдсэн навигаци, нислэгийн төлөвлөлт, нислэгийн дадлагажуур болон terrain awareness-ыг багтаасан өгөгдлийг;

means data used for an aeronautical application including navigation, flight planning, flight simulators, and terrain awareness, which comprises navigation data and terrain and obstacle data:

Нисэхийн байгууламж /Aeronautical facility гэж:

- (1) нисэхийн радио нэвтрүүлгийн үйлчилгээнд, эсхүл нисэхийн үндсэн үйлчилгээнд ашиглагдаж, ХНД/IFR-ийн нислэгт, эсхүл нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд дэмжлэг үзүүлж байгаа холбооны төрөл бүрийн системүүд; эсхүл
- (2) нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглагдаж байгаа холбооны төрөл бүрийн системийн суурин/газрын элементүүд; эсхүл

- (3) нисэхийн радио навигацийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа радио навигацийн төрөл бүрийн төхөөрөмжүүд; эсхүл
- (4) ХНД/IFR-ийн нислэгт, эсхүл нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд дэмжлэг үзүүлж байгаа бусад суурин/газрынхолбооны системүүд; эсхүл
- (5) нисэхийн хөдөлгөөнт радио давтамжууд дээр ажиллаж, цаг агаарын үндсэн мэдээлэл, аэродромын дотоод мэдээлэл, эсхүл нислэг дагах үйлчилгээнд ашиглагдаж байгаа газрын холбооны системийн төрлүүдийг;

means—

- (1) the various types of communication systems used for an aeronautical broadcasting service, or an aeronautical fixed service, that supports IFR flight or an air traffic service; or
- (2) the ground elements of the various types of communications systems used for an aeronautical mobile service; or
- (3) the various types of radio navigation aids used for the aeronautical radio navigation service; or
- (4) any other type of ground-based telecommunication system that supports IFR flight or an air traffic service; or
- (5) the various types of ground based telecommunication systems that operate in the aeronautical mobile radio frequency bands and are used to provide basic weather information, local aerodrome information, or flight following services:

Нисэхийн мэдээлэл /Aeronautical information гэж нисэхийн өгөгдлийг цуглуулан, задлан шинжилгээ хийж хэлбэржүүлсний үр дүнд бий болсон мэдээллийг;

means information resulting from the assembly, analysis and formatting of aeronautical data:

Нисэхийн мэдээллийн цуврал /Aeronautical Information Circular гэж:

- (1) NOTAM мэдээ үүсгэх, эсхүл Монгол Улсын НМЭ (AIP) -д оруулах шаардлагагүй;
- (2) нислэгийн аюулгүй байдал, агаарын навигаци, техник, захиргаа, эсхүл хууль зүйн холбогдолтой мэдээллийг агуулсан мэдээг;

means a notice containing information that—

- (1) does not qualify for the origination of a NOTAM or for inclusion in the AIP Mongolia; and
- (2) relates to flight safety, air navigation, technical, administrative or legislative matters:

Нисэхийн мэдээллийн эмхэтгэл /Aeronautical information publication (AIP) гэж тухайн улсаас, эсхүл тухайн улсын зөвшөөрлөөр эрхлэн гаргадаг, агаарын навигацид чухал шаардлагатай, тогтмол шинж чанартай нисэхийн мэдээллийг агуулсан хэвлэлийг;

means a publication issued by, or with the authority of, a State and containing aeronautical information of a lasting character essential to air navigation:

Нисэхийн мэдээллийн үйлчилгээ /Aeronautical information service (AIS) гэж Агаарын навигацийн аюулгүй байдал, тогтмол, үр ашигтай байдалд чухал ач холбогдолтой мэдээллийг түгээх дараах аль нэг үйлчилгээг:

- (1) AIP –ийн үйлчилгээ; эсхүл

(2) NOTAM үйлчилгээ; эсхүл

(3) Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ;

means any of the following services that distribute aeronautical information essential for the safety, regularity and efficiency of air navigation—

(1) AIP service; or

(2) NOTAM service; or

(3) Pre-flight information service:

Нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээ /Aeronautical mobile service гэж нисэхийн станцууд болон агаарын хөлгийн станцуудын хооронд, эсхүл агаарын хөлгийн станцуудын хооронд /үүнд аврах хэрэгслийн станцууд багтаж болно/-ын хөдөлгөөнт холбооны үйлчилгээ, энэ үйлчилгээнд мөн осол, сүйрлийн мэдээлэл дамжуулах зориулалттай давтамжууд дээр ажилладаг ослын байршил дамжуулагч станцуудыг багтааж болно;

means a mobile service for communication between aeronautical stations and aircraft stations, or between aircraft stations, in which survival craft stations may participate, and emergency position-indicating radiobeacon stations may also participate on designated distress and emergency frequencies:

Нисэхийн бүтээгдэхүүн /Aeronautical product гэж агаарын хөлгийн аливаа эд ангийг бүрдүүлж байгаа, эсхүл бүрдүүлэх зориулалттай, эсхүл суурилуулагдсан, эсхүл суурилуулах зориулалттай, эсхүл агаарын хөлөгт багтсан, эсхүл нийлүүлэгдсэн аливаа зүйл болон агаарын хөлгийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай түлш, бусад ижил төрлийн зарцуулалтын материалыг ;

means anything that comprises or is intended to comprise any part of an aircraft, or that is or is intended to be installed in or fitted or supplied to an aircraft; and includes fuel and other similar consumable items necessary for the operation of the aircraft:

Нисэхийн холбооны станц /Aeronautical station гэж нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээн дэх газрын станцыг;

means a land station in the aeronautical mobile service:

Нисэхийн холбооны үйлчилгээ /Aeronautical telecommunication service гэж:

(1) ИКАО-ийн Хавсралт 10-ын II Дэвтрийн Бүлэг 1-д тодорхойлогдсон, дараах үйлчилгээнүүдэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий холбооны үйлчилгээг:

(i) нисэхийн радио нэвтрүүлгийн үйлчилгээ;

(ii) нисэхийн суурин холбооны үйлчилгээ;

(iii) нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээ;

(iv) нисэхийн радио навигацгийн үйлчилгээ; эсхүл

(2) Монгол Улсын агаарын навигацгийн системд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн холбооны аливаа бусад үйлчилгээг;

means—

(1) a telecommunication service provided to support the following services as they are defined in ICAO Annex 10, Volume II, Chapter 1—

- (i) an aeronautical broadcasting service;
- (ii) an aeronautical fixed service;
- (iii) an aeronautical mobile service;
- (iv) an aeronautical radio navigation service; or

(2) any other telecommunication service provided specifically to support the Mongolian air navigation system:

Нисэхийн холбооны үйлчилгээний гэрчилгээ /Aeronautical telecommunication service certificate гэж Даргаас ИНД-171-ийн дагуу олгогдсон, нисэхийн холбооны үйлчилгээ үзүүлэх болон ХНД-ийн нислэгт, эсхүл Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх байгууламжийг ажиллуулах эрх олгож буй гэрчилгээг;

means a certificate issued by the Director in accordance with Part 171 that authorises the holder to provide aeronautical telecommunication services and operate facilities that support IFR flight or an air traffic service:

Нисэхийн мэдээллийн эмхэтгэлийн өөрчлөлт /AIP Amendment гэж Монгол Улсын НМЭ-д агуулагдсан мэдээлэлд оруулж буй тогтмол шинж чанартай өөрчлөлтийг;

means permanent changes to the information contained in the AIP NZ:

Нисэхийн мэдээллийн эмхэтгэлийн нэмэлт /AIP Supplement гэж Монгол Улсын НМЭ-д агуулагдсан мэдээлэлд оруулж буй, түр шинж чанартай, тусгай хуудсаар хэвлэгдэх өөрчлөлтийг;

means temporary changes to the information contained in the AIP NZ that are published by means of special pages

Нислэгийн хөдөлгөөн /Air traffic гэж нислэгт байгаа, эсхүл аэродромын маневрын талбайд үйл ажиллагаа явуулж байгаа бүх агаарын хөлгийг;

means all aircraft in flight or operating on any manoeuvring area of an aerodrome:

Нислэгийн хөдөлгөөний зөвлөмжийн үйлчилгээ /Air traffic advisory service гэж F ангиллын агаарын зайд ХНД /IFR-ийн нислэгийн төлөвлөгөөний дагуу нислэг үйлдэж буй агаарын хөлгүүдийн зайчлалыг хангах зорилгоор үзүүлж буй үйлчилгээг;

means a service provided within class F airspace to ensure separation, as far as practical, between aircraft that are operating on IFR flight plans:

Нислэгийн хөдөлгөөний хяналтын үйлчилгээ /Air traffic control service гэж дараах зорилгоор үзүүлж буй үйлчилгээг:

(1) мөргөлдөхөөс сэргийлэх—

- (i) агаарын хөлгүүд өөр хоорондоо;

(ii) аливаа маневрын талбай дээрх агаарын хөлгүүд өөр хоорондоо болон саадтай мөргөлдөхөөс;

(2) нислэгийн хөдөлгөөний урсгалыг аюулгүй, үр дүнтэй зохицуулах;

means a service provided for the purposes of—

(1) preventing collisions—

(i) between aircraft; and

ii) between aircraft and obstructions on any manoeuvring area; and

(2) expediting and maintaining a safe and efficient flow of air traffic:

Нислэгийн хөдөлгөөний хяналтын нэгж /Air traffic control unit гэж аливаа нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээний нэгж болон бүсийн удирдлагын төв, ойртолтын удирдлагын байр, эсхүл аэродромын удирдлагын цамхагийг;

means a unit for providing any air traffic control service, and includes either an area control centre, an approach control office, or an aerodrome control tower:

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ /Air traffic service гэж дараах Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг:

(1) аливаа аэродромын удирдлагын үйлчилгээ;

(2) аливаа бүсийн удирдлагын үйлчилгээ;

(3) аливаа ойртолтын удирдлагын үйлчилгээ;

(4) аливаа нислэгийн мэдээллийн үйлчилгээ;

(5) аливаа аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ;

(6) аливаа аюул, түгшүүрийн мэдээллийн үйлчилгээ;

(7) иргэний нисэхийн системийн аюулгүй, үр дүнтэй ажиллагаанд зайлшгүй шаардлагатай, эсхүл хэрэгтэй гэж Даргын тодорхойлсон нислэгийн хөдөлгөөний бусад үйлчилгээг;

Air traffic service includes—

(1) any aerodrome control service:

(2) any area control service:

(3) any approach control service:

(4) any flight information service:

(5) any aerodrome flight information service:

(6) any alerting service:

(7) any other air traffic service considered by the Director to be necessary or desirable for the safe and efficient operation of the civil aviation system:

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгж /Air traffic services unit гэж нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлж буй нэгжийг, үүнд нислэгийн

хөдөлгөөний удирдлагын нэгж болон нислэгийн мэдээллийн төв багтсан байж болно.

means a unit providing an air traffic service, which may include an air traffic control unit and a flight information centre:

Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ /Airworthiness certificate гэж:

- (1) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн хувьд, Даргаас ИНД-21-ийн "З" Бүлгийн дагуу олгосон нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ; болон
- (2) гадаадад бүртгэлтэй агаарын хөлгийн хувьд, Бүртгэгч улсын эрх бүхий байгууллагаас олгосон нислэгт тэнцэх чадварын гэрчилгээг;

means—

(1) for a Mongolian registered aircraft, an airworthiness certificate issued by the Director under Part 21, Subpart H; and

(2) for a foreign registered aircraft, an airworthiness certificate issued by the competent authority of the State of registry:

Нислэгт тэнцэх чадварын өгөгдөхүүн /Airworthiness data гэж нисэхийн бүтээгдэхүүн, эсхүл бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсэг нислэгт тэнцэх чадвартай гэдгийг бататгахад шаардлагатай аливаа мэдээллийг;

means any information necessary to ensure an aeronautical product or a product or component can be maintained in an airworthy condition:

Нислэгт тэнцэх чадварын удирдамж /Airworthiness directive гэж аюулгүй ажиллах нөхцлийг бататгах зорилгоор агаарын хөлөг, эсхүл нисэхийн бүтээгдэхүүнд хамаарах модификаци, үзлэг шалгалтууд, бодит нөхцөл байдлууд, эсхүл хязгаарлалтуудыг тодорхойлсон заавал биелүүлэх нислэгт тэнцэх чадварын шаардлагыг;

means a mandatory airworthiness requirement that specifies modifications, inspections, conditions, or limitations to be applied to an aircraft or aeronautical product to ensure continued safe operating conditions:

Нислэгт тэнцэх нөхцөл /Airworthy condition гэж агаарын хөлгийн загвар, үйлдвэрлэл, техник үйлчилгээ, модификаци, засвар болон аюулгүй байдлын талаарх Иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан, агаарын хөлгийн үйлдвэрлэл болон үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бүрдэл хэсгүүд, түлш болон бусад материалууд, бодисуудыг багтаасан агаарын хөлгийн нөхцөл байдлыг;

means the condition of an aircraft, including its components, fuel, and other materials and substances essential to the manufacture and operation of the aircraft, that complies with all the requirements prescribed by the Civil Aviation Rules relating to design, manufacture, maintenance, modification, repair, and safety:

Зөвшилцсөн стандарт /Consensus standard гэж спортын хөнгөн агаарын хөлгийг гэрчилгээжүүлэх зорилго бүхий, агаарын хөлгийн маяг, бүтээгдэхүүн болон нислэгт тэнцэх чадварт хамаатай нисэх онгоц үйлдвэрлэлийн салбарын стандартыг.

Энэ стандартад, агаарын хөлгийн загвар болон үзүүлэлт, шаардлагатай тоног төхөөрөмж, үйлдвэрлэгчийн чанар баталгаажуулалтын систем, бүтээгдэхүүнийг шалгаж баталгаажуулах журмууд, үйл ажиллагааны зааварчилга, техник үйлчилгээний болон үзлэгийн журмууд, их хэмжээний засвар болон их хэмжээний өөрчлөлтийг тодорхойлох болон мэдээлэх, нислэгт тэнцэх чадварын байнгын хадгалалтын стандартууд багтах боловч эдгээрээр хязгаарлагдахгүй;

means, for the purpose of certificating a light sport aircraft, an industry-developed standard that applies to the aircraft design, production, and airworthiness. The standard includes, but is not limited to, standards for aircraft design and performance, required equipment, manufacturer quality assurance systems, production acceptance test procedures, operating instructions, maintenance and inspection procedures, identification and recording of major repairs and major alterations, and continued airworthiness:

Нийт нөөц түлш /Final reserve fuel гэж нисэн очих, эсхүл нөөц, эсхүл тохиромжтой аэродромын бүсэд аливаа төлөвлөгдөөгүй маневр үйлдсэн тохиолдолд нислэгийг аюулгүй дуусгах шаардлагаар нөөцөлсөн, ердийн нөхцөлд буулт үйлдэхэд онгоцонд үлдэх минимум түлшний хэмжээг;

means the minimum quantity of fuel required to provide a margin to secure the safe completion of a flight in the event of any unplanned manoeuvring in the vicinity of the destination or alternate or a suitable aerodrome, as the case may be, and in ordinary circumstances remains on board until completion of the landing:

Нөөц түлш /Contingency fuel гэж дараах аль нэг тохиолдолд хэрэглэх түлшийг:

- (1) замын салхи, эсхүл агаарын хэм нь урьдчилсан мэдээнээс зөрүүтэй байх үед;
- (2) нислэгийн төлөвлөгөөнд тусгагдсан зам, өндөр, эсхүл нислэгийн түвшиний аливаа хазайлтын үед;
- (3) үйл ажиллагааны эдийн засгийн хэмнэлттэй горимоос хазайсан үед;

means a fuel provision for any of the following:

- (1) en-route winds or temperatures being different from forecast:
- (2) any deviation from the flight planned routes, altitudes or flight levels:
- (3) variations from optimum operating techniques

Нислэгийн хөдөлгөөний зөвшөөрөл /ATC clearance гэж нислэгийн хөдөлгөөний зохицуулалтын нэгжээс тодорхойлсон нөхцөлийг дагаж мөрдөх талаар агаарын хөлөгт олгож буй зөвшөөрлийг;

means authorisation for an aircraft to proceed under conditions specified by an air traffic control unit:

Нислэгийн хөдөлгөөний зааварчлага /ATC instruction гэж нислэгийн хөдөлгөөний зохицуулалтаас, тодорхой үйлдэл гүйцэтгэхийг нисгэгчээс шаардах зорилгоор өгч буй захирамжийг;

means a directive issued by ATC for the purpose of requiring a pilot to take a specific action:

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгж /ATS unit гэж нэг, эсхүл түүнээс дээш нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдсан нэгжийг;

means a unit established to provide one or more air traffic service:

Нисэхийн цугларалт /Aviation event гэж ИНД-91-д заасан тухайн минимум аюулгүй өндрөөс доор зохион байгуулагдах дараах арга хэмжээг:

- (1) агаарын шоу, эсхүл агаарын шоуны дасгал сургуулалт; эсхүл
- (2) агаарын уралдаан, эсхүл агаарын уралдааны дасгал сургуулалт; эсхүл
- (3) аэробатикийн нислэгийн тэмцээн; эсхүл
- (4) аэробатикийн сургалт, эсхүл дасгал сургуулалт;

means an event to be conducted below the minimum safe heights prescribed under Part 91 that is—

- (1) an air show or practice for an air show; or
- (2) an air race or practice for an air race; or
- (3) an aerobatic competition; or
- (4) aerobatic training or practice:

Нисдэг тэрэг /Helicopter гэж нэг, эсхүл хэд хэдэн даах сэнс агаартай харилцан үйлчилсний үндсэн дээр өргөх хүч үүсгэн нислэг үйлдэх роторт хөлгийг;

means a rotorcraft incorporating one or more power driven rotors:

Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ /Aviation Security Service гэж Иргэний нисэхийн тухай хуульд заасан Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг;

means the Aviation Security Service established under the Act

Нислэгт тэнцэх чадварын Онцгой удирдамж /Emergency airworthiness directive гэж Даргаас Иргэний нисэхийн тухай хуульд заасны дагуу гаргасан, заавал гүйцэтгэхийг шаардсан нислэгт тэнцэх чадварын удирдамжийг;

means an airworthiness directive that is issued by the Director in accordance with the Act

Нисэх багийн гишүүн /Flight crew member гэж нислэгт агаарын хөлгийн удирдлагатай холбоотой үүрэг гүйцэтгэхээр Үйл ажиллагаа эрхлэгчээс томилогдсон, зохих журмын дагуу мэргэшсэн нисгэгч, эсхүл нисэх-инженерийг;

means an appropriately qualified person assigned by the operator for duty in an aircraft during flight time as a pilot or flight engineer:

Нислэгийн үнэлгээ/ Flight evaluation гэж агаарын хөлгийн хэвийн үйл ажиллагааг тогтооход чиглэсэн бүх маневрууд болон хурдны хязгаарын хүрээнд, эдгээрээр дамжуулан агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар болон түүнийг удирдаж болох боломжийг шалгах нислэг, эсхүл хэд хэдэн нислэгийг;

means a flight or series of flights to test the airworthiness and controllability of an aircraft throughout its range of speeds and throughout all manoeuvres intended for the normal operation of the aircraft:

Нислэг дагах үйлчилгээ /Flight following service гэж агаарын хөлөгтэй холбоо тасарсан, эсхүл тусгайлан тогтоосон цагтаа ирээгүй тохиолдолд, онцгой байдлын арга хэмжээ эхлүүлэх зорилгоор агаарын хөлгийн нислэгийг тогтмол ажиглах үйлчилгээг;

means a service providing a flight watch over an aircraft, which initiates emergency action in the event of a missed report or non-arrival of the aircraft within a specific time-frame:

Нислэгийн мэдээллийн төв /Flight information centre гэж нислэгийн мэдээллийн болон түгшүүрийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдсан нэгжийг;

means a unit established to provide an area flight information service and an alerting service:

Нислэгийн мэдээллийн район /Flight information region гэж нислэгийн мэдээллийн үйлчилгээ болон түгшүүрийн мэдээллийн үйлчилгээ бүхий, тогтоогдсон хэмжээст агаарын зайг;

means airspace of defined dimensions within which flight information services and alerting services are provided:

Нислэгийн мэдээллийн үйлчилгээ /Flight information service гэж нислэгийн аюулгүй, үр ашигтай гүйцэтгэлийг хангах зорилгоор шаардлагатай мэдээлэл болон зөвлөмж өгөх/зөвлөмжөөр хангах нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг;

means an air traffic service provided for the purpose of giving advice and information intended for the safe and efficient conduct of flights:

Нислэгийн түвшин /Flight level гэж зуутын оронгоор илэрхийлэгдсэн агаар мандлын дараах тогтмол даралтын давхаргыг:

- (1) тогтсон стандарт 1013.2 гПа өгөгдөлтэй харьцуулсан;
- (2) тусгайлан заасан даралтын үечлэлээр бусад даралтын давхаргаас зайчлагдсан/тусгаарлагдсан

means a surface of constant atmospheric pressure expressed in terms of hundreds of feet that—
(1) is related to a specific datum 1013.2 hPa; and
(2) is separated from other such surfaces by specific pressure intervals:

Нислэгийн заавар /Flight manual гэж агаарын хөлгийн үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэхэд нисэх багийн гишүүдэд шаардлагатай зааварчилга, мэдээлэл, мөн

тухайн агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хязгаарлалтуудыг багтаасан, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй холбоотой зааврыг;

means a manual, associated with the certificate of airworthiness, containing limitations within which the aircraft may be considered airworthy, and instructions and information necessary to the flight crew members for the safe operation of the aircraft:

Нислэгийн төлөвлөгөө /Flight plan гэж агаарын хөлгийн төлөвлөж байгаа нислэг, эсхүл тухайн нислэгийн бүрдэл хэсгийн талаар нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжид, эсхүл нислэг дагах үйлчилгээнд өгөхийг дүрмээр шаардсан тодорхой мэдээллийг;

means specified information that is required under the rules to be provided to an ATS unit or to a flight following service regarding an intended flight, or portion of a flight, of an aircraft:

Нислэгийн цаг /Flight time гэж агаарын хөлөг нислэг үйлдэх зорилгоор анх хөдөлж эхлэх үеэс эхлэн, нислэг дуусаад бүрэн зогсох хүртэл, түрэх, явгалах болон хүлээх зэрэг холбогдох бүх цагийг багтаасан нийт цагийг;

means the total time from the moment an aircraft first moves for the purpose of flight until the moment it comes to rest at the end of the flight including all associated push back, taxiing and subsequent holding time:

Нисэхийн мэдээллийн нэгдсэн багц /Integrated Aeronautical Information Package гэж дараах элементүүдээс бүрдсэн багцыг:

- НМЭ, түүний өөрчлөлтийн үйлчилгээ;
- НМЭ-ийн нэмэлт;
- NOTAM мэдээ;
- Нисэхийн мэдээллийн цуврал (AIC);
- хүчинтэй NOTAM мэдээний жагсаалт болон хяналтын жагсаалт;

means a package which consists of the following elements—

- (1) AIP including amendment service:
- (2) supplements to the AIP:
- (3) NOTAM:
- (4) AIC:
- (5) checklists and summaries:

Нислэгт хөдөлгүүр унтрах /In-flight shutdown гэж:

- (1) нислэгт хөдөлгүүр өөрөө унтрах, эсхүл нисэх баг хөдөлгүүрийг унтраах, эсхүл дөл тасрах, дотоод эвдрэл, гадны биет орох, мөстөх зэргээр хязгаарлагдахгүй, бусад гадны нөлөөгөөр хөдөлгүүрийн үйл ажиллагаа зогсохыг; эсхүл
- (2) хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах хөдөлгүүрийн чадлыг гаргах, эсхүл удирдах боломжгүй болох, гэхдээ агаарт хөдөлгүүрийн үйл

ажиллагаа зогссон боловч хурдан хугацаанд автоматаар эргэж ассаныг тооцохгүй;

(1) when an engine ceases to function in flight and is shutdown, whether self induced, crew initiated or caused by some other external influence including but not limited to flameout, internal failure, foreign object ingestion, icing; or

(2) the inability to obtain or control thrust necessary for normal operations, but excludes the airborne cessation of the functioning of an engine when immediately followed by an automatic engine relight:

Нислэгт тэнцэх чадварын хадгалалтын зааварчилга /Instructions for continued airworthiness гэж нисэхийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсэг үйлдвэрлэгчээс гаргасан нислэгт тэнцэх чадварын өгөгдөл болон Зохион бүтээгч улсын нислэгт тэнцэх чадварын бүрэн эрхийн хүрээнд заавал хийхийг шаардсан нислэгт тэнцэх чадварын холбогдох хязгаарлалтуудыг;

means current airworthiness data provided by the manufacturer of an aeronautical product, a product, or a component, and include any related airworthiness limitations mandated by the airworthiness authority of the State of Design:

NOTAM гэж нисэхийн аливаа тоног төхөөрөмж, үйлчилгээ, журмын нөхцөл, эсхүл тэдгээрийн өөрчлөлт, эсхүл аюултай нөхцөл байдлын талаар нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа этгээдэд цаг тухайд нь урьдчилан мэдэгдэх зайлшгүй шаардлагатай, цахилгаан холбоогоор тараагдах мэдээг;

means a notice distributed by means of telecommunication containing information concerning the establishment, condition or change in any aeronautical facility, service, procedure or hazard, the timely knowledge of which is essential to personnel concerned with flight operations:

NOTAM мэдээний үйлчилгээ /NOTAM service гэж Монгол Улс Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэх үүрэг хариуцлага хүлээсэн бүсэд агаарын навигацид хамааралтай NOTAM мэдээ боловсруулах болон түгээх үйлчилгээг;

means a service for the issue and distribution of NOTAM relevant to air navigation in the Mongolian FIR in which Mongolia is responsible for air traffic services:

Нэг хөдөлгүүр татгалзсан үеийн аяллын хурд /One engine inoperative cruise speed гэж нөөц түлшний шаардлагыг тодорхойлох болон нэг хөдөлгүүр татгалзсан үеийн, тухайн нислэгийн даялалтын максимум хугацаанд, тогтуун агаарт нисэн хүрэх зайг тодорхойлох зорилгоор ашигладаг, Гэрчилгээ эзэмшигчийн сонгосон бөгөөд Даргын баталсан, онгоцны гэрчилгээжсэн хязгаарт байгаа хурдыг;

means a speed within the certified limits of the aeroplane, selected by the certificate holder and approved by the Director, that is used for calculating fuel reserve requirements and the still air distance associated with a one engine inoperative maximum diversion time for the flight:

Нислэгийн үйл ажиллагааны төлөвлөгөө /Operational flight plan гэж агаарын хөлгийн нислэг техникийн үзүүлэлтүүд, ашиглалтын хязгаарлалтууд, төлөвлөгдсөн чиглэлүүд болон аэродромд үүсэж болох нөхцлүүдийг тооцон, нислэгийг аюулгүйгээр гүйцэтгэх зорилгоор агаарын тээвэрлэгчийн зохиосон төлөвлөгөөг;

means the certificate holders plan for the safe conduct of the flight based on considerations of aeroplane performance, other operating limitations, and relevant expected conditions, on the route to be followed and at the aerodromes concerned:

Нарийвчлалтай ойртолтын журам /Precision approach procedure гэж азимут болон глиссадын мэдээллийг ашиглан хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг;

means an instrument approach procedure utilising azimuth and glide path information:

Нислэгийн өмнөх мэдээллийн товхимол /Pre-flight information bulletin гэж нислэгийн өмнө бэлтгэгдсэн, нислэгийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой, хүчинтэй NOTAM мэдээллийг;

means a presentation of current NOTAM information of operational significance, prepared prior to flight

Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ /Pre-flight information service гэж нислэгийн өмнөх төлөвлөлтөд зориулан Гуравдагч талыг нисэхийн мэдээллээр хангах үйлчилгээг;

means a service for the provision of aeronautical information to a third party for pre-flight planning purposes:

Нөөц шүхэр /Reserve parachute гэж үндсэн шүхэр татгалзсан үед хоёрдогч шүхрээр ашиглах зориулалтаар зохион бүтээгдсэн шүхрийн иж бүрдлийг;

means a parachute assembly designed and intended to be used as a secondary parachute in the event of the failure of the main parachute:

Ноцтой зөрчил /Serious incident гэж шинж чанараараа осолд хүргэх дөхсөн аливаа зөрчлийг;

means an incident involving circumstances indicating that an accident nearly occurred:

Үзүүлэлт /Specification гэж агаарын хөлөгт ашиглагдаж байгаа бүрэлдэхүүн хэсгийн минимум стандарт үзүүлэлтийг;

is the minimum performance standard specific to an article used on an aircraft:

Нойтон /Wet, гэж ХБЗ-ын хувьд, гадаргуу дээрээ ус мэт ойж харагдахуйц хангалттай хэмжээний чийгтэй, боловч их хэмжээний тогтоол устай талбайгүй ХБЗ-ыг

in relation to a runway, means a runway with sufficient moisture on its surface to cause it to appear reflective but without significant areas of standing water:

Олон улсын аэродром /International aerodrome гэж олон улсын нисэх буудлыг;

means an international airport:

Олон улсын нисэх буудал /International airport гэж олон улсын нислэгийг хүлээн авах болон явуулахад зориулагдсан, гааль, цагаачлалын алба, эрүүл ахуй, амьтан болон ургамлын хорио цээрийн хяналт зэрэгтэй ижил албан ёсны журмыг хэрэгжүүлдэг аливаа нисэх буудлыг;

means any airport designated as an airport of entry and departure for international air traffic where the formalities incident to customs, immigration, public health, animal and plant quarantine, and similar procedures are carried out:

Олон улсын NOTAM-ын нэгж /International NOTAM office (NOF) гэж тухайн улсаас томилогдсон, олон улсын хэмжээнд NOTAM мэдээ солилцох үүрэг бүхий нэгжийг;

means an office that is designated for the international exchange of NOTAM:

Олон улсын стандарт агаар мандал /International standard atmosphere гэж ICAO Document 7488 – ICAO Стандарт Агаар мандлын Зааварт заасан агаар мандлын стандартыг;

means the atmospheric standard as described in ICAO Document 7488 – Manual of the ICAO Standard Atmosphere:

Жагсаалын нислэг /Formation flight гэж нэгээс дээш агаарын хөлгийн дараах нислэгийг:

(1) ганц агаарын хөлөг шиг удирдуулж, мэдээлдэг;

(2) жагсаалын удирдагчаас хэвтээгээр 1.8 км (1nm)-ээс ихгүй, босоогоор 30м (100 feet)-ээс холгүй зайд жагссан;

means more than one aircraft which—

(1) navigate and report as a single aircraft; and

(2) are no more than one nautical mile laterally and within 100 feet vertically from the formation leader:

Ослын байрлал дамжуулагч /Emergency locator transmitter (ELT) гэж эрэн хайх, авран хамгаалах үйл ажиллагаанд туслах зорилгоор, тусгайлсан дохиог зориулалтын давтамжаар мэдээлэх төхөөрөмжийг;

means an equipment that broadcasts a distinctive signal on a designated radio frequency to facilitate a search and rescue operation:

Ослын байрлал дамжуулагч (суурин автомат) /Emergency locator transmitter (automatic fixed) гэж агаарын хөлөгт байнга суурилагдсан, автоматаар ажилладаг ослын байрлал дамжуулагчийг (ELT);

means an emergency locator transmitter that is automatically activated and permanently attached to an aircraft:

Ослын байрлал дамжуулагч (тусламжийн) /Emergency locator transmitter (survival) гэж ослын үед хэрэглэхэд бэлэн байхаар агаарын хөлөгт бэхлэгдсэн,

түүнээс салган авч болдог, гар ажиллагаатай ослын байрлал дамжуулагч (ELT)-ийг;

means an emergency locator transmitter that is stowed in an aircraft in a manner which facilitates its ready use in an emergency, is removable from an aircraft, and is manually activated:

Ослын байрлал заагч радио дохиологч /Emergency position indicating radio beacon гэж эрэн хайх, авран хамгаалах үйл ажиллагаанд туслах зорилгоор, тусгайлсан дохиог зориулалтын давтамжаар мэдээлэх, босоо байрлалтай хөвөхөөр зохион бүтээгдсэн, гар ажиллагаатай төхөөрөмжийг;

means an equipment that broadcasts a distinctive signal on a designated radio frequency to facilitate a search and rescue operation, is designed to float upright, and is manually activated:

Онгоц /Aeroplane гэж хүчний төхөөрөмжтэй, хөдөлгөөнгүй байрладаг гадаргууд аэродинамикийн нөлөөллөөр үүсэх өргөх хүчээр нислэг үйлддэг агаараас хүнд агаарын хөлгийг;

means a power-driven heavier-than-air aircraft deriving its lift in flight chiefly from aerodynamic reactions on surfaces which remain fixed under given conditions of flight:

Онгоцны хөдөлгөөн /Aeroplane movement гэж онгоцны хөөрөлт, эсхүл буултыг;

means an aeroplane take-off or landing:

Осол /Accident гэж аливаа этгээд нислэг үйлдэх болон зорчих зорилгоор агаарын хөлгийн бүхээгт орсон үеэс эхлэн, агаарын хөлөгт байгаа бүх этгээд хөлгийн бүхээгийг бүрэн орхих хүртэлх хугацаанд болсон хэрэг явдлыг:

(1) хэн нэгэн этгээд дараах нөхцөлд хүнд гэмтэл авах, эсхүл амь насаа алдах:

- (i) тухайн агаарын хөлөгт байх үедээ, эсхүл
- (ii) агаарын хөлөгтэй шууд буюу агаарын хөлгөөс салсан хэсэгтэй харьцсаны улмаас, эсхүл
- (iii) сэнс болон тийрэлтэт хөдөлгүүрийн хийн урсгалын шууд нөлөөлөлд орсны улмаас.

Жич: Биед ердийн шалтгаанаар үүссэн гэмтэл, өөрөө өөрийгөө гэмтээх, эсхүл ерөөл бусдаас гэмтэл авах, мөн тийзгүй зорчигч агаарын хөлөгт нуугдаж байрласнаас гэмтэл авах зэрэг тохиолдлууд үүнд хамаарахгүй.

(2) агаарын хөлөг гэмтэх, эсхүл түүний хийцэд эвдрэл гарсны улмаас:

- агаарын хөлгийн үндсэн хийцийн бөх бат чанар, эсхүл нислэг, техникийн үзүүлэлтүүд алдагдах,
- гэмтсэн бүрдэл хэсгийг солих, эсхүл их хэмжээний засвар шаардагдах.

Жич: Хөдөлгүүрийн эд анги, эсхүл капотын гэмтлээс шалтгаалан үүссэн хөдөлгүүрийн гэмтэл, эсхүл татгалзал, эсхүл сэнс, антенн, дугуй, тормоз зэргийн гэмтэл, эсхүл агаарын хөлгийн их биений гадаргууд үүссэн бага зэргийн хонхойлт, эсхүл цооролт зэрэг бусад гэмтэл, тохиолдлууд үүнд хамаарахгүй; эсхүл

(3) агаарын хөлөг сураггүй алга болох, эсхүл түүнд хүрэх боломжгүй байхыг;

An occurrence associated with the operation of an aircraft which takes place between the time any person boards the aircraft with the intention of flight until such time as all such persons have disembarked, in which:

- (a) a person is fatally or seriously injured as a result of:
- being in the aircraft, or
 - direct contact with any part of the aircraft, including parts which have become detached from the aircraft, or
 - direct exposure to jet blast,
- except when the injuries are from natural causes, self-inflicted or inflicted by other persons, or when the injuries are to stow aways hiding outside the areas normally available to the passengers and crew; or
- (b) the aircraft sustains damage or structural failure which:
- adversely affects the structural strength, performance or flight characteristics of the aircraft, and
 - would normally require major repair or replacement of the affected component, except for engine failure or damage, when the damage is limited to the engine, its cowlings or accessories; or for damage limited to propellers, wing tips, antennas, tires, brakes, fairings, small dents or puncture holes in the aircraft skin; or
- (c) the aircraft is missing or is completely inaccessible.

Ойртолтын зохицуулалтын/хяналтын төв /Approach control office гэж нэг, эсхүл хэд хэдэн аэродромоос нисэн гарах, эсхүл ирэх хяналттай нислэгүүдэд нислэгийн хөдөлгөөний зохицуулалтын үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдсан нэгжийг;

means a unit established to provide ATC service to controlled flights arriving at, or departing from, one or more aerodromes:

Ойртолтын зохицуулалтын/хяналтын үйлчилгээ /Approach control service гэж нисэн гарах, эсхүл ирэх хяналттай нислэгүүдэд зориулагдсан нислэгийн хөдөлгөөний зохицуулалтын үйлчилгээг;

means an air traffic control service for arriving or departing controlled flights:

Орон нутгийн аэродром /Domestic aerodrom гэж олон улсын аэродромоос бусад аливаа аэродромыг;

means any aerodrome other than an international aerodrome

Олон нисгэгчтэй агаарын хөлөг /Multi-pilot aircraft гэж ганц нисгэгчтэй агаарын хөлгөөс бусад агаарын хөлгийг;

means an aircraft other than a single-pilot aircraft:

Өргөн нэвтрүүлэг /Broadcast гэж бүх станцууд хүлээн авахад зориулсан дамжуулалтыг;

means a transmission intended to be received by all stations

Өдөр /Day гэж дараах хугацааг:

- (1) урган гарч буй нарны төв тэнхлэг тэнгэрийн хаяанаас 6 хэмээр дутуу гарах буюу үүрийн гэгээ эхлэхээс;
- (2) жаргаж буй нарны төв тэнхлэг тэнгэрийн хаяанаас 6 хэмээр доош орох буюу үдшийн бүрий хүртэлх хугацааг;

means the hours between—

- (1) the beginning of morning civil twilight, which is when the centre of the rising sun's disc is 6 degrees below the horizon; and
- (2) the end of evening civil twilight, which is when the centre of the setting sun's disc is 6 degrees below the horizon:

Өндөр /Height гэж объектын босоо хэмжээг багтаасан, тогтоогдсон эхлэлийн цэгээс хэмжсэн, түвшин, цэг, эсхүл цэгээр илэрхийлсэн объектын босоо зайг;

means the vertical distance of a level, a point, or an object considered as a point, measured from a specified datum and includes the vertical dimension of an object:

Өндөр хэмжигчийг QNH-д тохируулах /Altimeter setting (QNH) гэж газар дээрх өндөрлөгийн тэмдэглэгээг тодорхойлохдоо, өндөр хэмжигчийн туслах хуваарийг 1013.25 hectopascal-д, аэродромын даралтын түвшинг далайн дундаж түвшин хүртэл бууруулан, ICAO-ийн Стандарт Агаар мандлын нөхцөлийн дагуу далайн дундаж түвшинд, агаарын хэм 15°C байхад 1000м тутамд 6.5°C-ийн харьцаагаар тооцож тавьсан даралтыг;

means the aerodrome level pressure reduced to mean sea level in accordance with the ICAO Standard Atmosphere, which is specified by a mean sea level pressure of 1013.25 hectopascals and temperature of 15.0 degrees Celsius with a lapse rate of 6.5 degrees Celsius per 1000 M and is the altimeter sub scale setting to obtain the elevation when on the ground:

Өндөрлөгийн тэмдэглэгээ /Elevation гэж газрын гадаргуу дээр, эсхүл түүнд бэхлэгдсэн цэг, эсхүл түвшин хүртэл далайн дундаж түвшнээс хэмжсэн босоо зайг;

means the vertical distance of a point or a level, on or affixed to the surface of the earth, measured from mean sea level:

Түвшин /Level гэж нислэгт байгаа агаарын хөлгийн босоо байршилд хамаарах, өндөр, түвшин, эсхүл нислэгийн түвшин зэрэг олон утгатай ерөнхий ойлголтыг;

Level is a generic term relating to the vertical position of an aircraft in flight and meaning variously height, altitude, or flight level:

Өндөр алдах минимум түвшин /Minimum descent altitude гэж нарийвчлалтай бус ойртолтын, эсхүл тойргоор ойртолт үйлдэх /circling approach/ үед ил харааны баримжаагүйгээр өндөр алдаж болохгүй, далайн дундаж түвшинд харьцуулан тогтоосон түвшинг;

means a specified altitude, referenced to mean sea level, in a non-precision approach or circling approach below which descent may not be made without visual reference:

Өндөр алдах минимум өндөр / Minimum descent height гэж нарийвчлалтай бус ойртолтын, эсхүл тойргоор ойртолт үйлдэх /circling approach/ үед ил харааны баримжаагүйгээр өндөр алдаж болохгүй, зурвасны босгод харьцуулан тогтоосон өндрийг;

means a specified height, referenced to the runway threshold, in a non-precision approach or circling approach below which descent may not be made without visual reference:

Өмчлөгч /Owner гэж аливаа агаарын хөлгийн хувьд, агаарын хөлгийг 28 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар, хууль ёсоор эзэмшиж буй аливаа этгээдийг;

in relation to any aircraft, includes any person lawfully entitled to the possession of the aircraft for 28 days or longer:

Параглайдер /Paraglider гэж үндсэн бүтэц нь хатуу эд ангиас бүрдээгүй ханг-лайдерыг;

means a hang glider with no rigid primary structure:

Роторт хөлөг /Rotorcraft гэж ихэвчлэн босоо тэнхлэгт байрласан нэг, эсхүл хэд хэдэн роторт, агаарын урсгалын үйлчлэлээр өргөх хүч үүсэн нисдэг агаараас хүнд агаарын хөлгийг;

means any heavier-than-air aircraft which derives its lift in flight from the reaction of the air on one or more rotors on substantially vertical axes:

RNP үзүүлэлт /RNP performance гэж тухайн зорьж буй байрлалаас нислэгийн нийт цагийн 95%-аас багагүй хугацаанд нисэн хүрэх, далайн милээр хэмжигдсэн тогтоогдсон хяналтын тоог;

means a containment value, expressed as a distance in nautical miles from the intended position, within which flights would be for at least 95% of the total flying time:

Сайд /Minister гэж Тээврийн асуудал эрхэлсэн Сайдыг;

means the Minister of Transport:

Модификаци /Modification гэж бүтээгдэхүүн, бүрдэл хэсэг, эсхүл хэрэгслийг өөрчилсний үр дүнд загварын өөрчлөлт болохыг;

means a design change that generally results in a change to the configuration of a product, component, or appliance

Саадаас чөлөөтэй зурвас /Clearway гэж ХБЗ-ны хөөрөх төгсгөлд байгаа хуурай газар дээр, эсхүл усан дээр тогтоогдсон тэгш өнцөгт хэлбэрийн дараах талбайг:

- (1) аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн хяналтад байдаг; эсхүл
- (2) тухайн зурвасанд хяналт тавих эрх бүхий этгээдтэй тохиролцсоны дагуу сонгосон, эсхүл бэлтгэсэн, онгоц заагдсан өндөрт хүрэхийн тулд өндөр авах эхний шатны тодорхой үеийг нисэн өнгөрч болох тодорхой хэмжээний тохиромжтой талбайг;

means a defined rectangular area on the ground or water, at the departure end of the runway—
(1) under the control of the aerodrome operator; or
(2) with the agreement of the authority controlling the clearway—
selected or prepared as a suitable area over which an aeroplane may make a portion of its initial climb to a specified height:

Сонирхогчийн бүтээсэн агаарын хөлөг /Amateur built aircraft гэж ИНД-21-ийн "З" Бүлгийн дагуу сонирхогчийн бүтээсэн тусгай категорийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох боломжтой ба:

- (1) сонирхогч-зохион бүтээгч нь агаарын хөлгийн ихэнх хэсгийг өөрийн мэдлэг боловсрол, эсхүл ур чадварт тулгуурлан бүтээсэн; эсхүл
- (2) үйлдвэрлэгч нь туршилтын - спортын хөнгөн агаарын хөлөг гэж тодорхойлсон хөнгөн агаарын хөлгийг;

means an aircraft that is eligible for the issue of a special category—amateur-built airworthiness certificate under Subpart H of Part 21; and—
(1) the aircraft's amateur constructor has built the major portion of the aircraft for the constructor's own education or recreation; or
(2) the aircraft is a light sport aircraft designated by the manufacturer as an experimental – light sport aircraft:

Сонирхогч-зохион бүтээгч /Amateur constructor гэж зөвхөн өөрийн мэдлэг боловсрол, эсхүл ур чадварт түшиглэн агаарын хөлөг зохион бүтээгч этгээдийг;

means a person who constructs an aircraft solely for their own education or recreation:

Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа /Adventure aviation operation гэж нислэг, эсхүл тусгай зориулалтын /aerial/ нислэгт оролцож байгаа зорчигчид танин мэдэхүйн туршлага, дадлага олгох зорилгоор төлбөртэй тээвэрлэх дараах үйл ажиллагааг:

- (1) Стандарт категорийн Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй онгоц, эсхүл нисдэг тэргээр гүйцэтгэж буй загварын нислэг, аэробатикын маневрууд, огцом өндөр авах болон өндөр алдах, огцом эргэлтүүд зэрэг стандарт бус нислэгийн маневруудыг багтаасан А - А цэгт хүрэх нислэг;
- (2) Холбогдох тусгай категорийн– анхдагч, тусгай – категорийн LSA, эсхүл тусгай категорийн– хязгаарлагдмал нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй агаарын хөлгөөр гүйцэтгэж буй загварын нислэг, аэробатикын маневрууд, огцом өндөр авах болон өндөр алдах, огцом эргэлтүүд зэргийг багтаасан А-

А цэгт хүрэх нислэг (үүнд завьт онгоц /amphibious/-ны усан дээрх завсрын буулт мөн багтана);

- (3) 2-р ангиллын микролайт агаарын хөлгөөр гүйцэтгэж буй А-А цэгт хүрэх нислэг;
- (4) халуун агаарын бөмбөлөгийн нислэг;
- (5) глайдерын нислэг;
- (6) агаарын хөлгөөр шүхэр хаях үйл ажиллагаа /Дарга Иргэний нисэхийн хууль болон ИНД-119-ийн дагуу олгосон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнээс бусад/;
- (7) тандем- шүхрээр буух үйл ажиллагаа;
- (8) тандем- ханг-глайдер, эсхүл параглайдерын нислэг;

means the following operations for the carriage of passengers by air for hire or reward where the object of the operation is for the passenger's recreational experience of participating in the flight, or engaging in the aerial operation—

- (1) an A to A flight in an aeroplane or helicopter issued with a standard category airworthiness certificate conducting formation flight, aerobatic manoeuvres, and similar non-standard flight manoeuvres such as steep climbs, steep descents, and steep turns:
- (2) an A to A flight (including an interim water landing for amphibious aircraft) in an aircraft issued with an appropriate special category-primary, special category-LSA, or special category-limited airworthiness certificate including formation flight, aerobatic manoeuvres, and similar non-standard flight manoeuvres such as steep climbs, steep descents, and steep turns:
- (3) an A to A flight in a Class 2 microlight aircraft:
- (4) a flight in a hot air balloon:
- (5) a flight in a glider:
- (6) a parachute-drop aircraft operation that is not conducted under the authority of an air operator certificate issued by the Director under the Act and Part 119:
- (7) a tandem parachute descent operation:
- (8) a tandem hang glider or paraglider flight:

Сэнс /Propeller гэж хөдөлгүүрийн хөтлөгч голд бэхлэгдсэн алгануудтай, эдгээр нь эргэлдэн агаартай харилцан үйлчилснээр эргэлтийн талбайд перпендикуляр татах хүч үүсгэж хөлгийг хөдөлгөдөг төхөөрөмжийг;

Сэнсэнд, үйлдвэрлэгчээс хангадаг удирдлагын бүрдэл хэсгүүд багтах боловч үндсэн болон туслах ротор, эсхүл хөдөлгүүрийн эргэлдэгч эд анги (airfoils) багтахгүй.

means a device, for propelling an aircraft, that has blades on an engine-driven shaft and that when rotated produces by its action on the air, a thrust approximately perpendicular to its plane of rotation.

It includes control components normally supplied by its manufacturer, but does not include main and auxiliary rotors or rotating airfoils of engines:

SARTIME гэж түгшүүрийн арга хэмжээг эхлүүлэхээр нисгэгчийн тогтоосон цагийг; means the time nominated by a pilot for the initiation of alerting action:

SIGMET мэдээлэл /SIGMET information гэж тухайн нислэгийн замын дагуух, агаарын хөлгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй цаг агаарын аюултай

үзэгдэл ажиглагдсан, эсхүл ажиглагдах нөхцөл байдал үүссэн талаар Цаг уурын албанаас гаргасан мэдээллийг;

means information issued by a meteorological office concerning the occurrence or expected occurrence of specified enroute weather phenomena that may affect the safety of aircraft operations:

Синтетик нислэгийн дадлагажуур /Synthetic flight trainer гэж нислэгийн нөхцлүүдийг газар дээр дууриалган үйлдэж болох дараах тоног төхөөрөмжийг:

- (1) тодорхой маягийн агаарын хөлгийн нислэгийн бүхээг нь нисэх багийн гишүүдэд нислэгийн бодит нөхцөлийг бүрдүүлсэн, тухайн маягийн агаарын хөлгийн системүүдийн үйл ажиллагаа, нислэгийн өгөгдөхүүн, үзүүлэлтүүдийг **бодитоор** дууриалгасан нислэгийн симуляторыг;
- (2) агаарын хөлгийн бүхээгийн бодит орчинг бүрдүүлсэн, хэрэглэлийн заалтууд нь бодит үйлдэл бүхий энгийн системтэй, тодорхой ангилал (class), эсхүл маягийн агаарын хөлгийн нислэгийн өгөгдөхүүн болон үзүүлэлтүүдийг дууриалгасан нислэгийн журмын дадлагажуурын аппаратыг;
- (3) агаарын хөлгийн нислэгийн үеийн хэрэглэлийн нислэгийн бүхээгийн орчинг дууриамлаар бий болгоход шаардлагатай хэрэгслээр тоноглогдсон, нисгэгч дадлага авах, эсхүл хэрэглэлийн нислэгийн суурь маневр болон журмын шалгалт өгөхөд зориулагдсан хэрэглэлийн нислэгийн суурь дадлагажуурын аппаратыг;

means equipment in which flight conditions are simulated on the ground; and includes—

(1) a flight simulator, being an apparatus which provides an accurate representation of the flight deck of a particular aircraft type to the extent that the normal environment of flight crew members, the systems, and the performance and flight characteristics of that type are realistically simulated:

(2) a flight procedure trainer, being an apparatus that provides a representation of aircraft to the extent that realistic flight deck environment, instrument responses, simple systems, and the performance and flight characteristics of aircraft of a particular class or type are simulated:

(3) a basic instrument flight trainer, being an apparatus equipped with appropriate instruments, simulating the flight deck environment of an aircraft in flight in instrument flight conditions, in which a pilot may be instructed or tested in basic instrument flight manoeuvres and procedures:

Сэнсэн тийрэлтэт хөдөлгүүр /Turboprop гэж үлдэгдэл хийн урсгалын энергийг сэнс эргүүлэхэд ашигладаг хийн турбинт хөдөлгүүрийг;

means a gas turbine engine that uses the residual gas flow energy to drive a propeller:

Турбин хөдөлгүүрт /Turbine powered гэж турбин тийрэлтэт, эсхүл турбофан, эсхүл сэнсэн тийрэлтэт, эсхүл турбин голт хөдөлгүүртэй;

means powered by turbojet, or turbofan, or turboprop, or turboshaft:

Турбофан /Turbofan гэж турбин тийрэлтэт хөдөлгүүрийн дотоод контураас үүсэх хийн урсгалын үлдэгдэл энергийг ашиглан компрессорыг эргүүлж, хөдөлгүүрийн

дотоод контурын гадуурх агаарын урсгалын энергийг нэмэлт татах хүч болгон ашигладаг хөдөлгүүрийг;

means a turbojet core engine that uses a proportion of the residual gas flow energy to drive a compressor ducting gas flow around the core engine as additional propulsion

Турбин тийрэлтэт /Turbojet гэж үлдэгдэл хийн урсгалын энергийг шууд татах хүч болгон ашигладаг хийн турбинт хөдөлгүүрийг;

means a gas turbine engine that uses the residual gas flow energy directly as propulsion:

Турбин голт /Turboshaft гэж үлдэгдэл хийн урсгалын энергийг хөдөлгүүрийн голыг эргүүлэхэд ашигладаг хийн турбинт хөдөлгүүрийг;

means a gas turbine engine that uses the residual gas flow energy to drive a shaft:

Тандем мастер /Tandem master гэж тандем шүхрийн буултын шууд удирдлагыг хариуцсан этгээдийг;

means the person responsible for the direct control of a tandem parachute descent:

Тандем хос /Tandem pair гэж тандем мастер болон тандем зорчигчийг;

means a tandem master and tandem rider:

Тандем шүхрийн буулт /Tandem parachute descent гэж нийтлэг тандем шүхрийн иж бүрдлээр хийх тандем хосын шүхрийн буултыг;

means a parachute descent of a tandem pair in a common tandem parachute assembly:

Тандем зорчигч /Tandem rider гэж тандем бэхэлгээний системийн хоёрдогч бэхэлгээг ашиглан тандем шүхрийн буултад оролцож байгаа этгээдийг;

means a person participating in a tandem parachute descent using the secondary harness of a tandem harness system:

Техникийн зохицуулалт /Technical arrangement гэж агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт, техник үйлчилгээний стандарт болон бичиг баримт, хувь хүний үнэмлэх, гэрчилгээг харилцан зөвшөөрснөөр, нэг улсад агаарын хөлөг, түүний эд ангид хийгдсэн техник үйлчилгээг нөгөө улс нь гэрээний нөхцөлийн дагуу зөвшөөрөхөөр Монгол Улс болон бусад улсын хооронд байгуулсан зохицуулалтыг

means an arrangement between Mongolia and another State mutually recognise each State's aircraft maintenance organisation certification, maintenance standards and documentation, and personnel licences and certificates to allow maintenance performed on aircraft and components in one State to be

by the other State in accordance with the terms of the arrangement:

Техникийн өгөгдөл /Technical data гэж ИНД-21-ийн дагуу бүтээгдэхүүний гэрчилгээжүүлэлт, зөвшөөрөл болон эрх олгох, эсхүл ИНД-43-ын дагуу бүтээгдэхүүн, түүний бүрдэл хэсэг болон хэрэгслийн техник үйлчилгээ, модификаци болон засварт ашиглах шаардлагатай зураг, зааварчилгаа, эсхүл шаардлагатай бусад өгөгдлийг;

are drawings, instructions or other data required to be used for product certification, approvals, and authorisations under Part 21 or for the maintenance, modification, and repair of products, their components, and appliances under Part 43:

Техникийн зааварчилгаа /Technical Instructions гэж Конвенцийн Хавсралт 18-ын дагуу ICAO-ийн Зөвлөлийн шийдвэрээр батлагдаж, хэвлэгдсэн, Аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх Техникийн зааварчилгаа (ICAO Document 9284)-г;

means ICAO Document 9284 Technical Instructions for the Safe Transport of Dangerous Goods by Air approved and published by decision of the Council of the International Civil Aviation Organisation under Annex 18 of the Convention:

Техникийн бүртгэлийн дэвтэр /Technical log гэж ИНД-91.619-ийн дагуу холбогдох агаарын хөлөг бүрт шаарддаг техникийн бүртгэлийг;

means the technical log that is required for every applicable aircraft under rule 91.619:

Дүүжин /Hover гэж гадаргуугаас дээш, тогтмол өндөрт болон байрлалд хийх нисдэг тэрэгний нислэгийг;

means a helicopter flight at a constant height and position over the surface:

ТЕМРО гэж:

(a) TAF-д ашиглагдаж байгаа тохиолдолд, урьдчилсан мэдээний түр зуурын хэлбэлзэл нь цаг уурын нөхцөл тодорхой утганд хүрсэн, эсхүл давсан ба үргэлжлэх хугацаа нь тохиолдол бүрт 1 цагаас бага, хэлбэлзэлтэй өөрчлөлт ажиглагдахаар урьдчилан мэдээлсэн хугацааны хагасаас илүүгүй байна гэж тодорхойлсон утгыг; эсхүл

(b) TREND-д ашиглагдаж байгаа тохиолдолд, урьдчилсан мэдээний түр зуурын хэлбэлзэл нь цаг уурын нөхцөл тодорхой босго утганд хүрсэн, эсхүл давсан ба хэлбэлзэл бүрийн үргэлжлэх хугацаа 1 цагаас илүүгүй байна. Энэ хэлбэлзэл нь 2 цагийн турш ажиглагдах бол METAR, SPECI, эсхүл METAR AUTO-ийн цагт гаргах болон METAR, SPECI, эсхүл METAR AUTO-д давамгайлж байгаа нөхцөлүүдийг;

(a) when used in a TAF, means a description of forecast temporary fluctuations in the meteorological conditions which reach or pass specified values and last for a period of less than one hour in each instance and, in the aggregate, cover less than one-half of the period during which the fluctuations are forecast to occur; or

(b) when used in a TREND, means a description of forecast temporary fluctuations in the meteorological conditions, which reach or pass specified threshold values and last for a period of less than one hour in each instance. Such fluctuations are expected to occur during the 2 hours following the issue time of the METAR, SPECI or METAR AUTO, and to take place sufficiently infrequently for the prevailing conditions to remain those originally reported in the METAR, SPECI or METAR AUTO:

Тохирох, зөв хүн /Fit and proper person гэж тохирох, зөв хүний шалгуурыг хангасан этгээдийг;

means a person who satisfies the fit and proper person test:

Тээш /Baggage гэж үйл ажиллагаа эрхлэгчийн зөвшөөрлөөр агаарын хөлөгт тээвэрлэж буй зорчигчийн, эсхүл багийн гишүүдийн хувийн өмч хөрөнгө, эсхүл

агаарын хөлгөөр тээвэрлэхээр зорьж буй зорчигчийн, эсхүл багийн гишүүдийн хувийн өмч хөрөнгө;

means personal property of passengers or crew carried on an aircraft by agreement with the operator, or personal property of passengers or crew that is intended by passengers or crew to be carried on an aircraft:

Түвшин /Altitude гэж далайн дундаж түвшнээс хэмжсэн түвшний, цэгийн, эсхүл цэг гэж авч үзсэн объектын босоо зайг;

means the vertical distance of a level, a point, or an object considered as a point, measured from mean sea level:

Тохирох /Appropriate гэж нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн хувьд, ижил категорийн агаарын хөлөгт хамааралтай гэж ойлгоно;

in relation to a pilot licence or rating, means applicable to the same category of aircraft:

Нөхцөлт техник үйлчилгээ /Condition monitored maintenance гэж залруулах арга хэмжээ шаарддаг гэнэтийн татгалзлыг тодорхойлохын тулд, тухайн нийт эд ангийн ашиглалтын туршлагын дүн шинжилгээнд тулгуурласан, техник үйлчилгээний үйл явц, үр дүнд мониторинг хийдэг техник үйлчилгээний процессийг;

means a maintenance process that monitors maintenance trends, and relies upon analysis of the operating experience of the whole population of specified items to indicate nascent failures requiring corrective action:

Бүртгэлтэй үйлчлүүлэгч /Known customer гэж илгээгчийн ачаа, эсхүл шуудан агаараар тээвэрлүүлэхээр Зохицуулалттай агаарын ачааны байгууллага, эсхүл Агаарын тээвэрлэгчтэй холбоо тогтоосон, зохицуулалттай агаарын ачааны байгууллага, эсхүл Агаарын тээвэрлэгчид бүртгэлтэй ачаа, эсхүл шуудан илгээгчийг;

means a shipper of cargo or mail who has an established association with a regulated air cargo agent or an air operator for the carriage of the shipper's cargo or mail by air and who is registered with the regulated air cargo agent or the air operator:

Техник үйлчилгээ /Maintenance гэж агаарын хөлөг, эсхүл агаарын хөлгийн бүрдэл хэсгийн хувьд, агаарын хөлөг, эсхүл агаарын хөлгийн бүрдэл хэсэг болон бүх модификацийн нислэгт тэнцэх чадварын хадгалалтыг бататгахаар хийдэг бүх үзлэг болон ажлыг;

in relation to an aircraft or aircraft component, means all work and inspections performed to ensure the continued airworthiness of the aircraft or aircraft component, and all modifications:

Техник үйлчилгээний бүртгэлийн дэвтэр /Maintenance logbook гэж:

(1) хамааралтай байж болох дараах аль нэг бүртгэлийн дэвтрийг-

(i) САА 2101 Агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэр;

(ii) САА 2110 Сэнсний бүртгэлийн дэвтэр;

(iii) САА 2158 Хөдөлгүүрийн бүртгэлийн дэвтэр;

(iv) CAA 1464 Агаарын хөлгийн Нислэгт тэнцэх чадварын удирдамж, Агаарын хөлгийн модификаци, Хөдөлгүүр болон Сэнсний суурилуулалтын бүртгэлийн дэвтэр; эсхүл

(2) аливаа бусад баримт бичиг, эсхүл мэдээлэл хадгалагч нь —

(i) Даргын хүлээн зөвшөөрөхүйц;

(ii) агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эсхүл эд ангийн техник үйлчилгээний статусын бүртгэлийг агуулсан;

means—

(1) one of the following logbooks as may be appropriate:

(i) CAA 2101 Aircraft Logbook:

(ii) CAA 2110 Propeller Logbook:

(iii) CAA 2158 Engine Logbook:

(iv) CAA 1464 Aircraft Airworthiness Directives, Aircraft Modifications, Engine and Propeller Installations Logbook; or

(2) any other document or storage medium that—

(i) is acceptable to the Director; and

(ii) provides a record of the maintenance status of the aircraft, product, or component:

Техник үйлчилгээний заавар /Maintenance manual гэж тухайн агаарын хөлгийг нислэгт тэнцэх чадвартай гэж тооцогдож болох хязгаарлалтын хүрээ болон агаарын хөлөг нислэгт тэнцэх нөхцөлд байгааг бататгахад хэрэгцээтэй мэдээлэл, зааварчилгааг агуулсан, батлагдсан зааврыг;

means an approved manual containing limitations within which the aircraft may be considered airworthy, and instructions and information necessary to ensure the aircraft is in an airworthy condition:

Төсөөтэй олон систем /Multiple identical system гэж төсөөтэй системийн ижил элемент, гэхдээ EDTO нөлөө бүхий системээс тусдаа;

means the same element of an identical but separate EDTO significant system:

Төсөөтэй олон системийн техник үйлчилгээ /Multiple identical system maintenance гэж 2 турбин хөдөлгүүрт онгоцны хувьд, төсөөтэй олон системд хуваарьт, эсхүл хуваарьт бус техник үйлчилгээний үед, ижил цаг хугацаанд хийгдсэн техник үйлчилгээний ажиллагааг;

means for an aeroplane with 2 turbine powered engines, a maintenance action performed on multiple identical systems during the same period of scheduled or non-scheduled maintenance:

Үзүүлэлтийн доройтлын зөвшөөрөгдөх хязгаар /Performance deterioration allowance гэж тухайн онгоц үйлдвэрлэгчийн гаргасан, түлшний зарцуулалтын тоон хэмжээ болон тодорхой онгоцонд хамаарах түлшний бодит зарцуулалтын хоорондын ялгааг;

means the difference between the aeroplane manufacturer's published fuel consumption figures and the actual fuel consumption applicable to a specific aeroplane:

Туйлын бүс /Polar area гэж хойд өргөрөгийн 78 дугаар өргөрөгийн тэнхлэгээс хойшхи, эсхүл өмнөд өргөрөгийн 60 дугаар өргөрөгийн тэнхлэгээс урагших орон зайг;

means an area north of 78 degrees north latitude or an area south of 60 degrees south latitude:

Татах хүчний систем /Propulsion system гэж агаарын хөлгийн их биед суурилуулагдсан хөдөлгүүрийн татах хүч, эсхүл чадлыг удирдах болон түүний хяналтыг хэрэгжүүлэх бусад дэд системүүдийг агуулсан хөдөлгүүрийг;

means an engine and includes any associated item of equipment utilised for sustaining, monitoring and controlling the power or thrust output of an engine installed on the airframe:

Аэробатик нислэг /Aerobatic flight гэж—

- (1) агаарын хөлгөөр зориуд гүйцэтгэж буй шулуун нислэгээс эргэж доош харан нуруугаар нисэх, эсхүл шулуун нислэгээс хөрвөөж доош харан, эсхүл буцаж эргэн дээш харан нисэх нислэгийн маневрууд; эсхүл
- (2) хөрвөөх эргэлт, гогцоо, эргэлтэд орох, эгц дээш нисэн нуралтад орох /stall, hammer head, эсхүл whip stall/ зэрэг нислэгийн маневрууд, эсхүл эдгээрийн хослолыг;

means—

- (1) an intentional manoeuvre in which the aircraft is in sustained inverted flight or is rolled from upright to inverted or from inverted to upright position; or
- (2) manoeuvres such as rolls, loops, spins, upward vertical flight culminating in a stall turn, hammerhead or whip stall, or a combination of such manoeuvres:

Удирдлагын систем /Control system гэж нислэгийн зам, өндөр, эсхүл агаарын хөлгийн татах хүчийг шууд өөрчлөх чадвартай, нислэгийн хяналт, хөдөлгүүр болон сэнсний удирдлага, холбогдох бусад системийн удирдлага, болон холбогдох үйл ажиллагааны механизмуудыг багтаасан системийг;

means a system that has the ability to directly change the flight path, attitude, or propulsive force of an aircraft, and includes the flight controls, the engine and propeller controls, the related system controls, and the associated operating mechanisms:

Усан дээгүүрх алсын нислэгийн үйл ажиллагаа /Extended over-water operation гэж аливаа онгоцны үйл ажиллагааны төлөвлөгдсөн нислэгийн замд байгаа цэг нь эргээс 93 км (50nm) болон түүнээс алслагдсан зайтай байх нислэгийг;

means any aeroplane operation over a planned route that contains a point in excess of 50 nautical miles from shore

Үйлдвэрлэсэн огноо /Date of manufacture гэж бүтээгдэхүүний хувьд, маягийн загварын шаардлага хангасныг харуулж байгаа тухайн бүтээгдэхүүний үзлэгийн бүртгэлийн он, сар, өдрийг;

in relation to a product, means the date that the product inspection records indicate that the product meets its type design:

Үүлшлийн суурийн өндөр /Ceiling гэж газар, эсхүл усан гадаргуугаас дээш 6000м (20 000ft)-ээс доош өндөртэй, тэнгэрийн хагасаас илүүг бүрхэж байгаа хамгийн нам үүлэн давхаргын өндрийг;

means the height above ground or water of the base of the lowest layer of cloud below 20 000 feet (6000m) covering more than half the sky:

Үндсэн шүхэр /Main parachute гэж аврах шүхрээс бусад, үндсэн шүхрээр ашиглахаар зохион бүтээгдсэн шүхрийг;

means a parachute, other than an emergency parachute, that is designed and intended to be used as a primary parachute:

Их хэмжээний модификаци /Major modification гэж агаарын хөлгийн аюулгүй байдал, эсхүл түүний бүхээгт байгаа хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд нөлөөлөх боломжтой, эдгээрийн нэгдэл нь дараах нэг, эсхүл хэд хэдэн зөрчилд хүргэж болзошгүй модификацийг:

- (1) бүтцийн эвдрэл;
- (2) удирдлага алдагдах;
- (3) эх үүсвэрийн татгалзал;
- (4) агаарын хөлгийн үйл ажиллагаа, эсхүл аюулгүй байдалд зайлшгүй шаардлагатай аливаа системүүд, эсхүл тоног төхөөрөмжийн татгалзал, эсхүл санамсаргүйгээр/гэнэт ажиллах;
- (5) бүхээгт байгаа аливаа хүмүүст гэмтэл учруулах;
- (6) хэрэглэх, эсхүл ашиглахыг хүлээн зөвшөөрөх боломжгүй эвдрэл, гэмтэл;

means a modification that could potentially affect the safety of an aircraft or its occupants where, as a result of its embodiment, one or more of the following incidents may occur:

- (1) structural collapse:
- (2) loss of control:
- (3) failure of motive power:
- (4) unintentional operation of, or inability to operate, any systems or equipment essential to the safety or operational function of the aircraft:
- (5) incapacitating injury to any occupant:
- (6) unacceptable unserviceability or maintainability:

Их хэмжээний засвар / Major repair гэж хэрэгжүүлэлт нь агаарын хөлөг, эсхүл түүний бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд бодитоор нөлөөлөх, дараах нэг, эсхүл хэд хэдэн зөрчилд хүргэж болзошгүй засварыг:

- (1) бүтцийн эвдрэл;
- (2) удирдлага алдагдах;
- (3) эх үүсвэрийн татгалзал;

- (4) нислэгийн аюулгүй байдал эсхүл агаарын хөлгийн ажиллагаанд зайлшгүй шаардлагатай систем, эсхүл тоног төхөөрөмжийн санамсаргүй ажиллагаа, эсхүл эс ажиллагаа;
- (5) бүхээгт байгаа аливаа этгээдийг үүргээ гүйцэтгэх чадваргүй болгосон гэмтэл;
- (6) хэрэглээ нь, эсхүл ашиглалт нь хүлээн зөвшөөрөх боломжгүй болох;

means a repair that could potentially affect the safety of an aircraft or its occupants where, as a result of its embodiment, one or more of the following incidents may occur:

- (1) structural collapse:
- (2) loss of control:
- (3) failure of motive power:
- (4) unintentional operation of, or inability to operate, any systems or equipment essential to the safety or operational function of the aircraft:
- (5) incapacitating injury to any occupant:
- (6) unacceptable unserviceability or maintainability:

Үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хөтөлбөр / Manufacturer's maintenance programme гэж гэрчилгээжүүлэх эрх бүхий байгууллагын шаардлагын дагуу, Үйлдвэрлэгчээс агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, сэнс, ротор, хэрэгсэл, ослын тоног төхөөрөмж болон эд ангид зориулан гаргасан, Техник үйлчилгээний зааварт, эсхүл нислэгт тэнцэх чадварын хадгалалтын зааварчилгад заагдсан хөтөлбөрийг;

means a programme that is contained in a maintenance manual or the instructions for continued airworthiness published by the manufacturer as required by the certificating authority for the aircraft, aircraft engines, propellers, rotors, appliances, emergency equipment, and parts:

Үйл ажиллагаа явуулах /Operate гэж агаарын хөлгийн хувьд, тухайн этгээд нь агаарын хөлөгтэй хамт байгаа эсэхээс үл шалтгаалан, тухайн агаарын хөлгийг нисгэх, ашиглах, эсхүл тухайн агаарын хөлгийг нисэхийг зөвшөөрөх, эсхүл түүнд хүргэх шалтгаан болохыг;
"үйл ажиллагаа эрхлэгч"-ийг ижил утгаар ойлгоно.

in relation to an aircraft, means to fly or use the aircraft, or to cause or permit the aircraft to fly, be used, or be in any place, whether or not the person is present with the aircraft; and "operator" has a corresponding meaning:

Үйл ажиллагааны цикл /Operating cycle гэж хөөрөх, өндөр авах, чиг шулуун нислэгийн замын хэсэг, өндөр алдах болон буулт хийхээс бүрдсэн нислэгийн бүтэн үйлдлийг;

means a complete flight segment consisting of a takeoff, climb, en-route portion, descent, and landing:

Үйл ажиллагааны тодорхойлолт /Operations specifications гэж гэрчилгээний салшгүй хэсэг болох, Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээнд Даргын тогтоосон үйл ажиллагааны эрхийн хүрээ, хязгаарлалтууд болон журмуудыг агуулсан нөхцөлүүдийг;

means the conditions imposed by the Director on the air operator certificate and includes any authorisations, limitations, and procedures that form part of the certificate:

Үндсэн агаарын хөлөг /Originating aircraft гэж Монгол Улсын аль нэг аэродромоос зорчигч тээврийн тогтмол нислэгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа, өмнөх нислэг, эсхүл нислэгүүдийн төгсгөлд зорчигч болон ачаагаа буулгасан аливаа агаарын хөлгийг ойлгоно;
Үүнд, Монгол Улсыг, эсхүл түүний аль нэг нисэх буудлыг дамжин өнгөрч, нэмэгдэл зорчигч болон ачаа авч байгаа агаарын хөлгийг тооцохгүй.

means any aircraft about to be used on a regular air transport passenger service from any Mongolian aerodrome, that has been emptied of passengers and goods at the conclusion of a previous flight or flights, but does not include any aircraft transiting Mongolia, or any Mongolian airport, in circumstances where passengers and goods are added to an existing load:

Хэрэгсэл /Appliance гэж агаарын хөлгийн үйл ажиллагаанд, эсхүл агаарын хөлгийг нислэгт удирдахад ашиглахаар суурилуулсан, эсхүл суурилуулахаар төлөвлөж байгаа, эсхүл агаарын хөлөгт суурилагдсан, эсхүл бэхлэгдсэн, агаарын хөлгийн их бие, хөдөлгүүр, эсхүл сэнснээс бусад хэрэглэл, механизм, тоног төхөөрөмж, эд анги, эсхүл иж бүрдлийг;

means any instrument, mechanism, equipment, part, or accessory that is used, or is intended to be used, in operating or controlling an aircraft in flight, or is installed in or attached to the aircraft, that is not part of the airframe, engine, or propeller:

Удирдлагын зоон /Control zone гэж газрын гадаргуугаас дээш, тогтоосон хязгаар хүртэл үргэлжлэх удирдлагатай агаарын зайг;

means a controlled airspace extending upwards from the surface of the earth to a specified limit:

Удирдлагын бүс /Control area гэж газраас дээш, тодорхой өндрөөс дээш тогтоосон хяналттай агаарын зайг;

means a controlled airspace extending upwards from a specified limit above the earth:

Хяналттай агаарын зай /Controlled airspace гэж агаарын зайн ангиллын дагуу, ХНД / IFR болон ИХНД / VFR-ээр үйлдэж буй нислэгүүдэд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэхээр тогтоосон хэмжээст агаарын зайг;

means an airspace of defined dimensions within which air traffic control service is provided to IFR flights, and to VFR flights, in accordance with the airspace classification

Хяналттай нислэг /Controlled flight гэж Нислэгийн хөдөлгөөний удирдлагын зөвшөөрөл авах аливаа нислэгийг;

means any flight that is subject to an ATC clearance:

Хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа /Agricultural Aircraft Operation гэж ачаалах талбайгаас 8 км (5nm) дотор байрлаж буй үйл ажиллагааны

талбай хүртэлх нислэгийг багтаасан, дараах зорилгоор үйлдэгдэж буй нэг, эсхүл дараалсан нислэгийг:

- (1) газар тариалангийн химийн бодис цацах;
- (2) хөрс, ургамлын бордоо, тэжээл, эсхүл хортон шавьж устгах зориулалттай аливаа бусад бодис цацах;
- (3) газар тариалан, цэцэрлэгжилт, эсхүл ой хамгаалахад шууд чиглэсэн бодис цацах үйл ажиллагаа;
- (4) хөдөө аж ахуйн материал, хэрэгслийг агаараас хаях/буулгах, эсхүл хүргэж өгөх;
- (5) газар тариалан, ой мод, эсхүл усан гадаргуу дээгүүрх саадаас 150м (500ft)-ээс доош өндөрт тандалт судалгаа хийх;
- (6) хөдөө орон нутагт мал, эсхүл малын тэжээл зөөвөрлөн хүргэх;
- (7) дээрх төрлийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж буй бүсэд тандалт судалгаа хийх;

means the operation of an aircraft, on a single flight, or on a series of flights, including transit flights to and from a treatment area that is within 5 nautical miles (9.3km) of the loading area, for the following purposes:

- (1) dispensing an agricultural chemical;
- (2) dispensing any other substance intended for plant nourishment, soil treatment, propagation of plant life, or pest control;
- (3) engaging in dispensing activities directly affecting agriculture, horticulture, or forest preservation;
- (4) dropping farm supplies on farms in rural areas or delivering farm materials to farms in rural areas;
- (5) surveying agricultural, forest, or water areas at a height of less than 500 feet (150m) above terrain;
- (6) feeding or transferring livestock on farms in rural areas;
- (7) the reconnaissance of the proposed treatment area for the above types of operation.

Хөдөлгүүрийн өгөгдлийг автоматаар бичих систем /Automatic engine data recording system гэж агаарын хөлгийн хөдөлгүүрийн нислэгт тэнцэх нөхцөлтэй холбоотой төрөл бүрийн хэмжилтийн өгөгдлийг тусгай мэдрэгчүүдээс авч хадгалах системийг;

means a system that acquires data from specialised sensors that measure various parameters related to the airworthy condition of an aircraft engine:

Хамтран нисгэгч /Co-pilot гэж агаарын хөлгийн даргын үүргээс бусад, нисгэгчийн аливаа үүргийг гүйцэтгэж буй үнэмлэхтэй нисгэгчийг, үүнд тухайн агаарын хөлгийн бүхээгт нислэгийн зааварчилга авч буй нисгэгч хамаарахгүй;

means a licensed pilot, serving in any piloting capacity other than as pilot-in-command; but does not include a pilot receiving flight instruction from a pilot on board the aircraft

Хөгжлийн бэрхшээлтэй зорчигч /Disabled passenger гэж агаарын тээвэрийн үйл ажиллагааны үед бие махбодь, эрүүл мэнд, эсхүл сэтгэл зүйн нөхцөл нь бусад зорчигчоос илүү, тусгай анхаарал халамж шаарддаг зорчигчийг;

means any passenger whose physical, medical, or mental condition requires individual attention not normally extended to passengers during an air transport operation:

Хүчинтэй /Current гэж үнэмлэх, зэрэглэл, эсхүл эрүүл мэндийн гэрчилгээний хувьд, эдгээр баримт бичиг нь хүчинтэй бөгөөд тухайн баримт бичгийг эзэмшигч нь олгогдсон эрхийг хэрэгжүүлэхэд тавигдах мэргэжлийн ур чадварын хадгалалтын болон эрүүл мэндийн бүх шаардлагыг хангаж байгааг;

in respect of a licence, rating, or medical certificate, means the document is valid and the holder of the document has satisfied all recent experience and medical requirements for the exercise of the privileges

Хэлипорт /Heliport гэж бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн нисдэг тэрэгний хөөрөлт, буулт болон газар дээрх хөдөлгөөнд ашиглахаар зориулагдсан, эсхүл зохион бүтээгдсэн хуурай газар, эсхүл усан гадаргуу болон аливаа байгууламж дээр тогтоосон талбайг;

means any defined area of land or water, and any defined area on a structure, intended or designed to be used either wholly or partly for the landing, departure, and surface movement of helicopters:

Хуурай /Dry гэж ХБЗ-ны хувьд, нойтон, мөн бохирдсон болон чийгтэй үед ч хуурай тормозлох үйлдлийг сайжруулах зорилгоор товгор хээтэй, эсхүл чийг зайлуулах хучлагатай хийгдсэн зурвасыг;

in relation to a runway, means a runway that is neither wet nor contaminated, and includes a paved runway that has been specially prepared with grooves or a porous pavement to retain effectively drybraking action even when moisture is present:

Хамтарсан, хосолсон нислэгийн цаг /Dual flight time гэж этгээд нь хос удирдлагатай агаарын хөлгийн бүхээгт зохих ёсоор үнэмлэх болон зэрэглэл эзэмшсэн нисгэгчээс нислэгийн зааварчилгаа авч байгаа үеийн нислэгийн цагийг;

means flight time during which a person is receiving flight instruction from an appropriately licensed and rated pilot on board a dual control aircraft:

Хоосон жин /Empty weight гэж дараах зүйлүүдийг багтаасан агаарын хөлгийн хоосон жинг:

- (1) агаарын хөлгийн их бие, хөдөлгүүр, сэнс болон ротор;
- (2) агаарын хөлөгт суурилуулсан аливаа тоног төхөөрөмж;
- (3) агаарын хөлөгт суурилуулсан аливаа тэнцвэржүүлэгч;
- (4) агаарын хөлгийн хэрэглэгддэггүй түлш;

- (5) агаарын хөлгийн системүүдийн хэвийн үйл ажиллагаанд шаардлагатай дүүргэсэн шингэнүүд, үүнд цэвэр ус, жорлонгийн ус, агаарын хөдөлгүүрт хүч нэмэгдүүлэх зорилгоор хэрэглэх ус орохгүй;
- (6) Нислэгийн зааврын жин, балансын хэсэгт, эсхүл Нислэгийн заавар болон Хавсралтад заагдсан зүйлүүд;

means the empty weight of an aircraft, including—

- (1) the airframe, engines, propellers, and rotors of the aircraft; and
- (2) any fixed equipment on the aircraft; and
- (3) any fixed ballast on the aircraft; and
- (4) any unusable fuel on the aircraft; and
- (5) full operating fluids required for the normal operation of the aircraft's systems, except potable water, lavatory precharge water, and water intended for injection into the engines of the aircraft; and
- (6) items specified in the weight and balance section of the flight manual or flight manual and supplement:

Хэрэглэлээр ойртолт үйлдэх журам /Instrument approach procedure гэж анхан шатны ойртолтын үед нислэгийн хэрэглэлүүдээр заагдсан өгөгдлүүдийн дагуу саадыг тойрохоор урьдчилан тодорхойлогдож, тооцоологдсон нислэгийн үйлдлүүд, эсхүл хэрэв тогтоогдсон бол, нисэн ирэх замын эхлэлээс суух цэгийг хүртэл болон, хэрэв суулт үйлдэж чадаагүй бол агаарт хүлээх, эсхүл замын саадаас зайтай өнгөрөх шаардлагыг хангасан журмыг;

means a series of predetermined manoeuvres by reference to flight instruments with specified protection from obstacles from the initial approach fix, or where applicable, from the beginning of a defined arrival route, to a point from which a landing can be completed and thereafter, if a landing is not completed, to a position at which holding or en-route obstacle clearance criteria apply:

Хэрэглэлийн нислэг /Instrument flight гэж агаарын хөлөг гадны баримжаалах цэгүүдийг ашиглахгүйгээр, зөвхөн хэрэглэлийн заалтын тусламжтайгаар нисэхийг;

means flight during which an aircraft is piloted solely by reference to instruments and without external reference points:

Хэрэглэлийн нислэгийн журам /Instrument flight procedure гэж ХНД-ээр дараах үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт хамаарах, эсхүл багтах ил харааны, эсхүл хэрэглэлийн нислэгийн журмыг:

ХНД-ийн нисэн гарах болон нисэн ирэх маршрутыг багтаасан ХНД-ийн нислэгийн зам;

ХНД-ийн түвшин;

Стандарт Хэрэглэлээр нисэн ирэх;

Стандарт Хэрэглэлээр нисэн гарах;

Онцгой цэгүүд багтсан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй;

Навигацийн туслах тоноглол шилжүүлэх цэг;

ХНД/IFR-ийн мэдээлэх цэг;

ХНД-ийн онцгой цэг;

Тогтоосон цэг;

ХНД-ийн хүлээх зам;

холбогдох 2-т гарах журам болон цаг уурын хязгаарлалтыг багтаасан, Хэрэглэлээр ойртолт үйлдэх журам;

хэрэглэлээр нисэн гарах журам болон цаг уурын холбогдох хязгаарлалт;

means a visual, or an instrument, flight procedure that comprises, or is associated with, any of the following for the operation of aircraft under IFR:

IFR routes, including IFR arrival routes and IFR departure routes:

IFR altitude:

standard instrument arrival:

standard instrument departure:

significant points including but not limited to:

navigation aid change over point:

IFR reporting point:

significant IFR point:

fix:

IFR holding pattern:

instrument approach procedure including, the associated missed approach procedure and meteorological minima:

instrument departure procedure and the associated meteorological minima:

Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээ /Instrument flight procedure service гэж хэрэглэлийн нислэгийн журам зохиох, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх, эсхүл засварлах үйлчилгээг;

means a service that includes the design, validation, certification, or maintenance of an instrument flight procedure:

Хэрэглэлийн нислэгийн цаг /Instrument flight time гэж агаарын хөлөг гадны баримжаалах цэгүүдийг ашиглахгүйгээр, зөвхөн хэрэглэлийн заалтын тусламжтайгаар ниссэн хугацааг;

means time during which an aircraft is piloted solely by reference to instruments and without external reference points:

Хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөл /Instrument meteorological conditions гэж алсын барааны харагдац, үүл хүртэлх зай ба үүлний доод суурийн өндөр нь ил харааны нислэгийн цаг уурын нөхцөлийн хязгаарлалтаас доош илэрхийлэгдэх нөхцөлүүдийг;

means meteorological conditions expressed in terms of visibility, distance from cloud, and ceiling less than the minima specified for visual meteorological conditions:

Хэрэглэлийн ХБЗ /Instrument runway гэж Хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг ашиглаж буй агаарын хөлгийн үйл ажиллагаанд зориулагдсан ХБЗ-г;

means a runway intended for the operation of aircraft using instrument approach procedures:

Хэрэглэлийн цаг /Instrument time гэж хэрэглэлийн нислэгийн цаг болон зөвшөөрөгдсөн механик хэрэгслээр хэрэглэлийн нислэг үйлдсэн дадлагын цагийг;

includes instrument flight time and time during which a pilot is practising simulated instrument flight on an approved mechanical device:

Хөөрөлтийг зогсоох боломжит зай /Accelerate-stop distance available гэж хөөрөлт үйлдэхээр гүйх зам болон аливаа зогсох замын уртын нийлбэрийг;

means the length of the take-off run available plus the length of any stop way:

Хөөрөлтийн боломжит зай /Take-off distance available гэж хөөрөлтийн гүйлтэд шаардлагатай/боломжтой зурвасны урт дээр аливаа саадаас чөлөөтэй хэсгийн уртыг нэмж тооцсоныг;

means the length of the take-off run available plus the length of any clearway

Хөөрөлтийн боломжит урт /Take-off run available гэж Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчээс, агаарын хөлөг хөөрөхөөр гүйхэд тохиромжтой ба боломжтой гэж зарласан ХБЗ-ны уртыг;

means the length of the runway declared by the aerodrome operator as available and suitable for the ground run of an aeroplane taking-off:

Хөөрөлтийн жин /Take-off weight гэж хөөрөлтийн гүйлт үйлдэхийн өмнө онгоцонд, эсхүл онгоцон дээр байгаа бүх зүйл болон бүх хүмүүсийг багтаасан, зурвасны эхэнд хөөрөх зорилгоор гүйлт үйлдэх үеийн онгоцны жинг;

means the weight of the aeroplane at the commencement of the take-off run and includes everything and everyone carried in or on the aeroplane at the commencement of the take-off run:

Хууль /Act гэж Иргэний нисэхийн тухай хуулийг;

the Civil Aviation Act

Хөдөлгүүрт глайдер /Powered glider гэж хөдөлгүүртэй, эсхүл хөдөлгүүр ажиллагаагүй үед глайдерийн нислэгийн үзүүлэлттэй, нэг, эсхүл хэд хэдэн хөдөлгүүртэй агаарын хөлгийг;

means an aircraft equipped with one or more engines which has, with the engine or engines not operating, the performance characteristics of a glider:

Хөөрөлтийн гэрчилгээжсэн максимум жин / Maximum certificated take-off weight гэж агаарын хөлгийн хувьд, тухайн агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээнд, эсхүл нислэгийн зааварт хөөрөлтийн максимум жин гэж тусгагдсан жинг;

in relation to an aircraft, means the weight specified as the maximum take-off weight of the aircraft in a flight manual or airworthiness certificate relating to the aircraft:

Хөдөлгөөний талбай / Movement area гэж агаарын хөлгийн хөөрөлт болон буулт, мөн газар дээр хөдөлгөөн хийхэд зориулагдсан, маневрын талбай, техник үйлчилгээний талбай болон апроныг багтаасан аэродромын тодорхой хэсгийг;

means that part of an aerodrome intended to be used for the take-off and landing of aircraft and for the surface movement of aircraft, and includes the manoeuvring area, maintenance areas, and aprons:

Хөдөө аж ахуйн агаарын хөлгийн арилжааны үйл ажиллагаа /Commercial agricultural aircraft operation гэж хөлс, эсхүл шан урамшуулалтай гүйцэтгэгч байгаа хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагааг;

means an agricultural aircraft operation for hire or reward:

Шигүү суурьшлын бүс /Congested area гэж хот, эсхүл суурингийн хувьд, орон сууц, үйлдвэрлэл, арилжааны эсхүл амралт зугаалгын зорилгоор голчлон ашигладаг аливаа талбайг;

in relation to a city, town, or settlement means any area which is substantially in use for residential, industrial, commercial, or recreational purposes:

Хяналттай аэродром /Controlled aerodrome гэж аэродромын хөдөлгөөнд нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлдэг аэродромыг;

Тайлбар- “хяналттай аэродром” гэдэг ойлголт нь тухайн аэродромд, аэродромын хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэхээс биш, нислэгийн хөдөлгөөний хяналттай бүс заавал байна гэсэн үг биш юм.

means an aerodrome at which air traffic control service is provided to aerodrome traffic:

Note — the term ‘controlled aerodrome’ indicates that air traffic control service is provided to aerodrome traffic but does not necessarily imply that a control zone exists.

Чухал эд анги/ Priority part гэж эд анги, эсхүл иж бүрдлийн татгалзал нь агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, эсхүл сэнсийг аюултай байдалд хүргэх шалтгаан болох маягийн гэрчилгээтэй бүтээгдэхүүнийг;

means a part or assembly in a type certificated product, the failure of which is likely to cause an unsafe condition in an aircraft, aircraft engine or propeller:

Хэсэгчилсэн үзлэг /Progressive inspection гэж агаарын хөлгийг бүхэлд нь хэд хэдэн хэсгүүдэд хувааж хийх жижиг үзлэгийг;

means an inspection of a complete aircraft that is split into a number of smaller inspections:

Хөөрч, буух зурвас (ХБЗ) /Runway гэж агаарын хөлгийн буулт, хөөрөлтөд зориулан бэлдсэн, газрын аэродром дээр тогтоосон тэгш өнцөгт талбайг;

means a defined rectangular area on a land aerodrome prepared for the landing and take-off of aircraft:

ХБЗ-ны төгсгөлийн аюулгүй талбай /Runway end safety area (RESA) гэж ХБЗ-ны төгсгөлөөс үргэлжлүүлэн, төвийн шугамын дагуу тэгш хэмтэй байрлах, онгоц зурвасанд дутуу орж ирж суух, эсхүл зурваснаас давж гарах үеийн эрсдлийг багасгах үндсэн зориулалттай талбайг;

means an area symmetrical about the extended centre line of the runway and adjacent to the end of the runway strip primarily intended to reduce the risk of damage to an aeroplane undershooting or over-running the runway

ХБЗ-ны стрип /Runway strip гэж ХБЗ болон хэрэв байгаа бол зогсоох зурвас (stopway)-ыг багтаасан, дараах зорилгоор тогтоосон тодорхой талбайг;

- (1) ХБЗ-аас гарах агаарын хөлгийн гэмтэх эрсдлийг багасгах;
- (2) Хөөрөлт, эсхүл буултын үед түүний дээгүүр нисэж буй агаарын хөлгүүдийн саадыг давах аюулгүй ажиллагааг хангах;

means a defined area including the runway, and stopway (if a stopway is provided), that is intended—

- (1) to reduce the risk of damage to an aircraft running off the runway; and
- (2) to provide obstacle protection for aircraft flying over the runway strip during take off or landing operations:

ХБЗ-ны алсын барааны харагдац /Runway visual range гэж ХБЗ-ны гадаргуу дээрх тэмдэглэгээ, тэнхлэгийн, эсхүл хязгаарын тэмдэглэгээ ба гэрлүүд нь ХБЗ-ны тэнхлэгийн шугам дээр байгаа, агаарын хөлгийн нисгэгчид харагдах зайг;

means the range over which the pilot of an aircraft on the centre line of a runway can see the runway surface markings or the lights delineating the runway or identifying its centreline:

ИХНД-ийн тусгай нислэг /Special VFR flight гэж хяналттай агаарын зайд, нислэгийн хөдөлгөөний зохицуулалтын нэгжийн зөвшөөрлөөр, Ил харааны цаг уурын нөхцөлөөс бага үед ИХНД/VFR-ээр нисэхийг;

means a VFR flight cleared by an ATC unit to operate within controlled airspace in meteorological conditions below visual meteorological conditions:

Хоорондын хугацаа /Threshold time гэж:

- (1) 2 турбинт хөдөлгүүрт онгоцны хувьд 60 минут;
- (2) 2-оос дээш турбинт хөдөлгүүрт онгоцны хувьд 180 минут;

means—

- (1) 60 minutes for an aeroplane with 2 turbine powered engines; and
- (2) 180 minutes for an aeroplane with more than 2 turbine powered engines:

Хөдөлгөөний мэдээлэл /Traffic information гэж мөргөлдөхөөс зайлсхийхэд нь нисгэгчид туслах зорилгоор, агаарын хөлгийн байрлалд, эсхүл нислэгийн чиглэлд ойртолт үүсгэж болзошгүй, мэдэгдэж байгаа, эсхүл тогтоогдсон нислэгийн хөдөлгөөний талаар нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжээс нисгэгчид өгч буй анхааруулах мэдээг;

means information issued by an ATS unit, to alert a pilot to other known or observed air traffic which may be in proximity to the position, or intended route of flight, and to help the pilot avoid a collision:

Хууль бус халдлага / Unlawful interference гэж зорчигч, багийн гишүүн, газрын ажилтан, агаарын хөлөг, эсхүл байгууламж, тоног төхөөрөмжид аюул учруулах үйлдэл, эсхүл завдсан үйлдлийг;

means an act or attempted act endangering a passenger, crew member, ground personnel, aircraft, or facility:

Хүнгүй агаарын хөлөг /Unmanned aircraft гэж бүхээгтээ нисгэгчгүйгээр ажиллахаар зохион бүтээгдсэн бөмбөлөг, утсаар удирдах агаарын хөлгийн загвар, чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар болон зайнаас удирддаг агаарын хөлгийг;

means an aircraft designed to operate with no pilot on board and includes unmanned balloons, control line model aircraft, free flight model aircraft and remotely piloted aircraft:

Хүнгүй агаарын хөлгийн систем /Unmanned aircraft system гэж бүхээгтээ нисгэгчгүйгээр ажилладаг агаарын хөлөг болон түүний холбогдох элементүүдийг;

means an aircraft and its associated elements which are operated with no pilot on board:

Хүчинтэй /Valid гэж:

- (а) үнэмлэх, эсхүл зэрэглэлийн хувьд, Иргэний нисэхийн багц дүрмийн хүрээнд олгогдсон баримт бичгийн хугацаа нь дуусаагүй, түдгэлзүүлээгүй, эсхүл хүчингүй болгогдоогүйг;
- (б) Эрүүл мэндийн гэрчилгээний хувьд, ИНД-67-ийн дагуу олгогдсон ба хугацаа нь дуусаагүй, түдгэлзүүлээгүй, эсхүл хүчингүй болгоогүй байхыг;

means:

- (a) in respect of a licence or rating, the document has been issued in accordance with the Civil Aviation rules, and is not expired, suspended, or revoked; and
- (b) in respect of a medical certificate, the medical certificate has been issued in accordance with the Part 67, and is not expired, suspended, or revoked.

Цаг агаарын үндсэн мэдээ /Basic weather report гэж нисэхийн үйл ажиллагаанд зориулагдсан, тодорхой газар нутаг, эсхүл агаарын зайн тухайн үеийн цаг агаарын байдлын талаарх дараах аман мэдээллийг:

- (1) салхины чиглэл болон хүч;
- (2) далайн түвшний агаарын даралтын дундаж утга;
- (3) агаарын температур;
- (4) цаг агаарын нөхцөл ба үүлний бүрхэц;

means a verbal comment, in support of aviation, describing any of the following current weather conditions observed at a particular place or airspace:

- (1) wind direction and strength:
- (2) mean sea level air pressure:
- (3) air temperature:
- (4) weather conditions and cloud cover:

Цаг уурын мэдээлэл /Meteorological information гэж цаг уурын мэдээ, дүн шинжилгээ, эсхүл урьдчилсан мэдээ болон нисэхийн үйл ажиллагаанд зориулагдсан цаг уурын тухайн үеийн, эсхүл ирээдүйн төлөвийг илэрхийлсэн аливаа бусад нөхцөлүүдийг;

means any meteorological report, analysis, or forecast in support of aviation, and any other statement in support of aviation relating to existing or expected meteorological conditions:

Цаг уурын үйлчилгээ /Meteorological service гэж нисэхийн үйл ажиллагаанд зориулагдсан дараах аль нэг цаг уурын үйлчилгээг:

- (1) Уур амьсгалын үйлчилгээ: тодорхой газар нутаг, эсхүл агаарын зайд зориулсан уур амьсгалын мэдээлэл боловсруулах болон түүгээр хангах үйлчилгээ;
- (2) Урьдчилан мэдээлэх үйлчилгээ: тодорхой газар нутаг, эсхүл агаарын зайн хэсэгт зориулсан цаг уурын урьдчилсан мэдээллээр хангах үйлчилгээ;
- (3) Мэдээлэл түгээх/дамжуулах үйлчилгээ: цаг уурын мэдээллийг цуглуулах болон дамжуулах үйлчилгээ;
- (4) Цаг уурын мэдээний тайлбар өгөх үйлчилгээ: цаг уурын одоогийн болон ирээдүйн нөхцөл байдлын талаар бичгээр болон амаар тайлбарлан мэдээлэх үйлчилгээ;
- (5) Цаг уурын мэдээний үйлчилгээ: замын цаг агаарын мэдээгээр хангах үйлчилгээ;
- (6) Цаг уурын ажиглалтын/хяналтын үйлчилгээ: тодорхой бүс нутаг дахь агаарын хөлгийн үйл ажиллагаанд нөлөөлөх цаг уурын нөхцөлд ажиглалт хийх/хяналт тавих үйлчилгээ;

means any of the following services that provide meteorological information in support of aviation:

- (1) Climatology service: a service for the development and supply of climatological information for a specific place or airspace:
- (2) Forecast service: a service for the supply of forecast meteorological information for a specific area or portion of airspace:
- (3) Information dissemination service: a service for the collection and dissemination of meteorological information:
- (4) Meteorological briefing service: a service for the supply of written and oral meteorological information on existing and expected meteorological conditions:
- (5) Meteorological reporting service: a service for the supply of routine meteorological reports:
- (6) Meteorological watch service: a service for maintaining a watch over meteorological conditions affecting aircraft operations in a specific area:

Цагийн хязгаарт систем /Time limited system гэж тогтоогдсон цагийн хязгаарлалттай онгоцны аль нэг системээс тухайн онгоцны боломжит нислэгийн цагийн үргэлжлэх хугацаа хамаарах системийг;

means any system on an aeroplane that has a defined time limited capability and on which the duration of the available flight time of the aeroplane is dependent on:

Чадвар алдагдсан /Impaired гэж ядаргаа, гэмтэл, эрүүл мэндийн нөхцөлийн улмаас, эсхүл согтууруулах ундаа, эсхүл өөрийн, эсхүл бусдын аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй бусад эм бэлдмэл хэтрүүлэн хэрэглэхийг;

means affected by fatigue, injury, medical condition, or by the consumption of alcohol or other drugs such that the person may be a risk to the safety of himself or herself or of any other person:

Нислэгийн шалгагч /Flight examiner гэж ИНД-61-ийн дагуу олгосон нислэгийн шалгагчийн зэрэглэл эзэмшиж буй, эсхүл Даргаар зөвшөөрөгдсөн тухайлсан нислэгийн шалгалт гүйцэтгэх этгээдийг;

means a person who holds a flight examiner rating issued in accordance with Part 61 or is approved by the Director to conduct specific flight tests:

Шилжин сурах зааварчилга /Conversion instruction гэж маягийн зэрэглэл шаардлагатай агаарын хөлгийн үйл ажиллагаатай танилцах зорилгоор авч буй зааварчилгыг, гэхдээ үүнд, сурагч-нисгэгчид өгөх зааварчилга, эсхүл түүний хяналт, мөн далавчит агаарын хөлгөөс роторт агаарын хөлөг рүү, эсхүл роторт агаарын хөлгөөс далавчит агаарын хөлөг рүү шилжихтэй холбоотой танилцах зааварчилга орохгүй;

means instruction for the purposes of familiarisation in the operation of aircraft for which a type rating is required; but does not include instruction or supervision of student pilots nor instruction for the purposes of familiarisation in respect of conversion from fixed-wing to rotary-wing aircraft or from rotary-wing to fixed-wing aircraft:

Шийдвэр гаргах түвшин /Decision altitude гэж хэрэв ойртолтыг үргэлжлүүлэхэд шаардлагатай ил харааны баримжааг тогтоож чадаагүй бол нарийвчлалтай ойртолтын үед хоёрт гарах үйлдлийг гүйцэтгэх ёстой, далайн түвшинтэй харьцуулан тогтоосон өндрийг;

means a specified altitude, referenced to mean sea level, in the precision approach at which a missed approach must be initiated if the required visual reference to continue the approach has not been established:

Шийдвэр гаргах өндөр /Decision height гэж хэрэв, ойртолтыг үргэлжлүүлэхэд шаардлагатай ил харааны баримжааг тогтоож чадаагүй бол нарийвчлалтай ойртолтын үед хоёрт гарах үйлдлийг гүйцэтгэх ёстой, зурвасны босготой харьцуулан тогтоосон өндрийг;

means a specified height, referenced to the runway threshold, in the precision approach at which a missed approach must be initiated if the required visual reference to continue the approach has not been established:

Шуудан /Mail гэж шуудан тээвэрлэгч, шуудангийн оператор, эсхүл шуудангийн бусад байгууллага, эсхүл дипломат байгууллагаар дамжин хүргэгдэх аливаа захидал, боодол, илгээмж, ил захидал, эсхүл бусад зүйлийг;

means any letter, package, parcel, postcard, or other article that is to be delivered by courier, a postal operator, or other postal agency, or diplomatic agency:

Түлшгүй максимум жин / Maximum zero fuel weight гэж ашиглагддаггүй түлш, эсхүл тосгүй агаарын хөлгийн зөвшөөрч болох максимум жинг. Түлшгүй максимум жингийн диаграммыг агаарын хөлгийн маягийн гэрчилгээний өгөгдлийн хуудас, Агаарын хөлгийн нислэгийн заавар, эсхүл эдгээрийн аль алианаас харж болно;

means the maximum permissible weight of an aircraft with no disposable fuel or oil. The zero fuel weight figure may be found in either the aircraft type certificate data sheet, the approved Aircraft Flight Manual, or both:

Шинэхэн засварласан /Newly overhauled гэж засвар хийсэнээс хойш, ажиллагааны тест хийснээс өөрөөр, ажилаагүй, эсхүл ашиглалтанд гаргаагүй бүтээгдэхүүнийг;

means a product that has not been operated or placed in service, except for functional testing, since having been overhauled:

Шөнө / Night гэж:

- (1) жаргаж буй нарны төв тэнхлэг тэнгэрийн хаяанаас 6 хэмээр доош орон, нар шингэхээс;
- (2) урган гарч буй нарны төв тэнхлэг тэнгэрийн хаяанаас 6 хэмээр дутуу гаран, нар мандахын хоорондох хугацааг;

means the hours between—

(1) the end of evening civil twilight, which is when the centre of the setting sun's disc is 6 degrees below the horizon; and

(2) the beginning of morning civil twilight, which is when the centre of the rising sun's disc is 6 degrees below the horizon

Шүхэр /Parachute гэж үйл ажиллагаандаа хөдөлгүүр хэрэглэдэггүй, удирдагддаг эсэргүүцэлтэй, эсхүл өргөх хүч нь эсэргүүцлээр бий болдог, гадаргуугаас ачаалал нь утсан холбоосоор дамжин тардаг, эвхэгдсэн байдлаас удирдан задалж болдог аливаа төхөөрөмжийг;

means any device, without a motor in operation, comprising a flexible drag, or lift/drag, surface from which a load is suspended by shroud lines capable of controlled deployment from a packed condition:

Шүхрийн иж бүрдэл /Parachute assembly гэж аливаа этгээд ашиглахад зориулсан шүхэр, түүний холбогдох уяа холбоос, сав баглааны систем болон бусад бүрэлдэхүүн хэсгийг;

means any parachute and its associated harness and container system and other component parts for use by persons:

Шүхэр буух талбай /Parachute landing area гэж дээр нь шүхрийн буулт хийхээр төлөвлөсөн талбайг;

means an area onto which parachute landings are intended to be made:

Шүхрийн байгууллага /Parachute organization гэж ИНД-149-ийн дагуу шүхрийн үйл ажиллагаатай холбоотой эрх олгогдсон, Нисэх клубын гэрчилгээ эзэмшигчийг;

means the holder of an aviation recreation organisation certificate issued in accordance with Part 149 that authorises specified privileges associated with parachute operations:

Үзлэг шаардсан /Required inspection гэж ИНД, НТЧ-ын удирдамж, эсхүл зөвшөөрөгдсөн Техник үйлчилгээний заавар, хөтөлбөр, эсхүл хуваариар шаардсан аливаа үзлэгийг;

any inspection required by the CAR, an airworthiness directive, or by an approved maintenance manual, programme or schedule:

Шилжүүлэх тээш /Transfer baggage гэж нэг агаарын хөлгөөс нөгөө агаарын хөлөг рүү шууд шилжүүлж буй тээшийг;

means baggage that is transferred directly from one aircraft to another aircraft:

Шилжилтийн зам /Translation circuit гэж нисдэг тэрэгний урагш давших нислэгт шилжих шилжилтийг багтаасан замыг;

means a circuit in a helicopter that includes translation to forward flight:

Эрх бүхий байгууллага /Authority гэж Иргэний нисэхийн тухай хуулийн дагуу байгуулагдсан Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газрыг;

means the Civil Aviation Authority of Mongolia established by the Act:

Эрсдэлтэй гүйцэтгэлийн параметр /Critical performance parameter гэж нисэхийн байгууламжийн үйл ажиллагааны цогц байдалд шууд нөлөө үзүүлж буй ажиллагааны хүчин зүйлийг;

means a performance parameter that has a direct effect on the operational integrity of an aeronautical facility:

Энгийн үзлэг /Routine inspection гэж хэсэгчилсэн үзлэгийн хувьд, бүх боломжт хэлбэрээр задаргаа хийхгүйгээр агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг, систем болон тоног төхөөрөмжид хийх нүдэн үзлэгийг;

in relation to a progressive inspection, means a visual inspection of an aircraft and its components, systems and equipment as far as practicable without disassembly:

Эрэг /Shore гэж устай хиллэсэн, газар дээрх усны түвшингээс дээшхи талбайг. Үүнд зарим үед усанд автдаг газар орохгүй;

means that area of the land adjacent to the water that is above the high-water mark and excludes land areas that are intermittently under water:

UNICOM үйлчилгээ /UNICOM Service гэж нисэхийн үйл ажиллагааг хялбарчлах зорилгоор аэродромын мэдээллээр хангах нисэхийн хөдөлгөөнт газрын радио холбооны үйлчилгээг;

UNICOM нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ биш.

means a ground radio communications service in the aeronautical mobile service providing local aerodrome information for the facilitation of aviation, and, for the avoidance of doubt, a UNICOM service is not an air traffic service:

Явгалалт /Taxi гэж аэродром, эсхүл усан гадаргуу дээгүүрх агаарын хөлгийн хөөрөлт, буултаас бусад хөдөлгөөн, нисдэг тэрэгний хувьд газрын нөлөөний үйлчлэлд хамаарах өндөрт, агаараар явгалах хурдаар гүйцэтгэж буй аэродромын гадаргуу дээрх үйл ажиллагааг;

means movement of an aircraft on the surface of an aerodrome or on water, excluding take-off and landing, but including, in the case of helicopters, operation over the surface of an aerodrome within a height band associated with ground effect and at speeds associated with air taxiing:

Явгалах түлш /Taxi fuel гэж хөдөлгүүр асаахаас, хөөрөх зорилгоор гүйлт үйлдэж эхлэх хүртэл болон газардсаны дараа ХБЗ-аас эргэн гарахаас, хөдөлгүүр унтраах хүртэл агаарын хөлгийн үйл ажиллагаанд шаардлагатай түлшийг;

means the fuel required for the operation of an aircraft between the engine start to commencement of the take off run and between the runway turnoff following completion of landing run to engine shut down:

1.3 Товчлол

ACC (Area control centre) - Бүсийн удирдлагын төв

ACAS (Airborne collision avoidance system) - Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем

AD (Airworthiness directive) - Нислэгт тэнцэх чадварын удирдамж

ADF (Automatic direction-finder) - Автомат пеленгатор

AEDRS (Automatic engine data recording system) – Хөдөлгүүрийн өгөгдлийг автоматаар бичих систем

AFRU (Aerodrome Frequency Response Unit) - Аэродромын давтамжийг хариулах нэгж:

AFS (Aeronautical fixed service) - Нисэхийн суурин үйлчилгээ

AFTN (Aeronautical fixed telecommunication network) - Нисэхийн цахилгаан холбооны суурин сүлжээ

- AGL (Above ground level) - Газрын түвшнээс дээш
- AIC (Aeronautical Information Circular) - Нисэхийн мэдээллийн цуврал
- AIP (Aeronautical Information Publication) - Нисэхийн мэдээллийн эмхэтгэл
- AIP Mongolia (Aeronautical Information Publication of Mongolia) – Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэл
- AIS (Aeronautical Information Service) - Нисэхийн мэдээллийн үйлчилгээ
- AMC (Accredited medical conclusion) – Итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт
- AMSL (Above mean sea level) - Далайн дундаж түвшнээс дээш
- AQP (Advanced qualification programme) - Гүнзгийрүүлэн мэргэшүүлэх хөтөлбөр
- ARC (Aerodrome reference code) - Аэродромын заагдсан код
- ARFL (Aeroplane reference field length) – Онгоцны зурвасны заагдсан урт
- ASDA (Accelerate-stop distance available) - Хурдатгалыг зогсоох боломжит зай
- ATC (Air traffic control) - НХУ (Нислэгийн хөдөлгөөний удирдлага)
- ATCRBS (Air traffic control radio beacon system) - Нислэгийн хөдөлгөөний зохицуулалтын/хяналтын радио дохиологч систем
- ATS (Air traffic services) – НХУ (Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ)
- ATIS (Automatic terminal information service) - Терминалын автомат мэдээллийн үйлчилгээ
- AWIB (Aerodrome and Weather Information Broadcast) – Аэродромын болон цаг уурын мэдээлэл дамжуулагч
- BRNAV (Basic area navigation) - Навигацийн үндсэн бүс
- BTPD (Body temperature and pressure dry) – Биеийн хэм ба хуурай даралт
- BTPS (Body temperature and pressure standard)- Биеийн хэм ба даралтын стандарт
- CAR (Civil Aviation Rules) - ИНД (Иргэний нисэхийн дүрмүүд)
- CBIP (Certification Board for Inspection Personnel) – Хяналтын ажилтны гэрчилгээжүүлэлтийн зөвлөл
- CMP (Configuration, maintenance and procedures standards document) Конфигураци, техник үйлчилгээ болон үйл ажиллагааны стандарт баримт бичиг

CRM (Crew resource management) – Нисэх багийн хүний хүчин зүйлийн менежмент

DA (Decision altitude) - Шийдвэр гаргах түвшин

DH (Decision height) - Шийдвэр гаргах өндөр

dBm (Power expressed in decibels with a reference level of 1milliwatt) – 1 милливатт түвшинг децибилээр илэрхийлсэн чадлыг

dBW (Power expressed in decibels with a reference level of 1 watt) -1 ватт түвшинг децибилээр илэрхийлсэн чадлыг

DF (Direction finding) – Радиопеленгатор

DME (Distance measuring equipment) - Зай хэмжих төхөөрөмж

EDTO (Extended diversion time operation) – Даялалтын хугацааг сунгасан нислэгийн үйл ажиллагаа

EET (Estimated elapsed time) – Тооцоот өнгөрөлтийн цаг

ELT (Emergency locator transmitter) - Ослын байрлал дамжуулагч

ELT (AF) (Emergency locator transmitter (automatic fixed) - Ослын байрлал дамжуулагч (суурин автомат)

ELT(S) (Emergency locator transmitter (survival) - Ослын байрлал дамжуулагч (тусламжийн)

EPIRB (Emergency position indicating radio beacon) - Ослын байрлал илтгэгч радио станц

ETA (Estimated time of arrival) - Нисэн ирэх тооцоот цаг

ETOPS (Extended-range twin-engine operations) - Хоёр хөдөлгүүрт агаарын хөлгийн алсын зайн нислэгийн үйл ажиллагаа

FAR (Federal Aviation Regulations issued by the Federal Aviation Administration of the United States of America) – АНУ-ын Холбооны Нисэхийн Удирдах Газраас гаргасан Холбооны Нисэхийн Дүрмүүд

FDPS (Flight data processing system) - Нислэгийн өгөгдөл боловсруулах систем

FIC (Flight information center)-Нислэгийн мэдээллийн төв

FIR (Flight information region) - Нислэгийн мэдээллийн район

GAA (General aviation area) - Ерөнхий нислэгийн бүс

GPS (Global positioning system) - Сансрын навигацийн байрлал тодорхойлох систем

GPWS (Ground proximity warning system) - Газар ойртсоныг анхааруулах систем

HF (High frequency) - Өндөр давтамж

ICAO (International Civil Aviation Organisation) – Олон улсын иргэний нисэхийн байгууллага

IFR (Instrument flight rule) - Хэрэглэлийн нислэгийн дүрэм (ХНД)

IFSD (In-flight shut down) – Нислэгт хөдөлгүүр унтрах

ILS (Instrument landing system) - Хэрэглэлээр буулт үйлдэх систем

IMC (Instrument meteorological conditions) – Хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөл

ISA (International standard atmosphere) – Олон улсын стандарт агаар мандал

LDA (landing distance available) – Буултын боломжит зай

LOC (localizer) - Локалайзер

LRNS (long range navigation system) - Алсын зайн навигацийн систем

LSA (Light Sport Aircraft) – Спортын хөнгөн агаарын хөлөг

MCTOW (Maximum certificated take-off weight) – Хөөрөлтийн гэрчилгээжсэн максимум жин

MDA (Minimum descent altitude)- Өндөр алдах минимум түвшин

MDH (Minimum descent height) – Өндөр алдах минимум өндөр

ME1 (Medical examiner who holds a Medical Examiner 1 Certificate issued under the rule) - ИНД-ийн дагуу олгогдсон 1 дүгээр ангиллын Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ эзэмшигчийг

ME2 (Medical examiner who holds a Medical Examiner 2 Certificate issued under the rule) – ИНД-ийн дагуу олгогдсон 2 дугаар ангиллын Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ эзэмшигчийг

MEL (Minimum equipment list) – Минимум тоног төхөөрөмжийн жагсаалт

MLS (Microwave landing system) - Буулт үйлдэх хэт богино долгионы систем

MNPS (Minimum navigation performance specifications) – Навигацийн минимум үзүүлэлтийн тодорхойлолт

NDT (Non-destructive testing) - Үл эвдэх сорил

NDB (Non-directional radio beacon) – Чиглүүлэгч радио станц

NDT (Non-destructive testing) – Үл эвдэх сорилын үзлэг шалгалт

NOF (International NOTAM office) – Олон улсын NOTAM-ын Алба

Mongolian ANR (Mongolian Air Navigation Register) – Монгол Улсын Агаарын Навигацийн Бүртгэл

Mongolian PMA (Mongolian Parts Manufacturing Approval) – Монгол Улсын эд анги үйлдвэрлэх зөвшөөрөл

Mongolian TSO (Mongolian Technical Standard Order) – Монгол Улсын Техникийн стандарт

OGE (Out of ground effect) - Газрын нөлөөллөөс ангид

PAR (Precision approach radar) – Нарийвчлалтай ойртолтын радар

PIB (Pre-flight Information Bulletin) – Нислэгийн өмнөх мэдээллийн бюллетен

PLA (Parachute landing area) - Шүхэр буух талбай

PLB (Personal locator beacon) – Хувийн байрлал дохиологч

PRA (Precision radar approach) – Нарийвчлалтай ойртолтын радар

PSR (Primary surveillance radar) – Анхдагч хяналтын радар

QFE (Atmospheric pressure at aerodrome level or at runway threshold) - Аэродромын түвшин дэх, эсхүл зурвасны босгон дээрх агаар мандлын даралт

QNH (An altimeter sub-scale setting to obtain elevation when on the ground) – газар дээрх өндөрлөгийн тэмдэглэгээг тогтоох зорилгоор өндөр хэмжигчийн туслах хуваарийг тохируулах

ESA (Runway end safety area) – ХБЗ-ны төгсгөлийн аюулгүй талбай

RF (Radio frequency) – Радио давтамж

RFDPS (Radar and flight data processing system) – Радар болон нислэгийн өгөгдөл боловсруулах систем

RDPS (Radar data processing system) – Радарын өгөгдөл боловсруулах систем

RF (Radio frequency) - Радио давтамж

RNAV (Area navigation) – RNAV (Бүсийн навигаци)

RNP (Required navigation performance) – RNP (Навигацийн шаардлагатай үзүүлэлт)

RPM (Revolutions per minute) - Нэг минутанд эргэх тоо

RVR (Runway visual range) - Зурвасны дагуух алсын барааны харагдац

RVSM (Reduced vertical separation minimum) – RVSM (Багасгасан босоо зайчлалын минимум)

SEIFR (Single-engine IFR) – SEIFR (Ганц хөдөлгүүртийн ХНД)

SELCAL (Selective calling system) – SELCAL (Дуудлага анхааруулах систем)

SFAR (Special Federal Aviation Regulations issued by the Federal Aviation Administration of the United States of America) – АНУ-ын Холбооны Нисэхийн Удирдах Газраас гаргадаг Холбооны Нисэхийн Тусгай дүрмүүд

SSR (Secondary surveillance radar) – SSR (Хяналтын хоёрдогч радар)

STC (Supplemental Type Certificate) – Нэмэлт маягийн гэрчилгээ

STPD (Standard temperature and pressure dry) – Стандарт хэм болон хуурай даралт

TAWS (Terrain awareness and warning system) – Гадаргууг мэдрэх ба анхааруулах систем

TBO (Time between overhaul) – Их засварын хоорондох хугацаа

TCAD (Traffic alert and collision avoidance device) - Хөдөлгөөнийг анхааруулах ба мөргөлдөхөөс сэргийлэх төхөөрөмж

TCAS (Traffic alert and collision avoidance system) - Хөдөлгөөнийг анхааруулах ба мөргөлдөхөөс сэргийлэх систем

TODA (Take-off distance available) – Хөөрөлтийн боломжит зай

TORA (Take-off run available) – Хөөрөлтийн боломжит урт

TSO (Technical standard order that is issued by the Federal Aviation Administration of the United States of America) – АНУ-ын Холбооны Нисэхийн Удирдах Газраас гаргадаг Техникийн стандарт

UAS (Unmanned aircraft system) – Хүнгүй агаарын хөлгийн систем

UF (Uplink formats) – Үндсэн сүлжээний формат

UHF (Ultra high frequency)

UTC (Co-ordinated universal time) - Олон улсын цаг /GMT/

V1 (Take-off decision speed) - Хөөрөлтийн үед шийдвэр гаргах хурд

V2 (Take-off Safety speed) - Хөөрөлтийг үргэлжлүүлж болох аюулгүй хурд

VEF (Calibrated speed at which the critical engine is assumed to fail)- Хөдөлгүүр татгалзсан үед тохируулсан хурд

VS (Stalling speed) - Унах хурд

VFR (Visual flight rules) - Ил харааны нислэгийн дүрэм (ИХНД)

VHF (Very high frequency) - Хэт өндөр давтамж

VMC (Visual meteorological conditions) - Ил харааны нислэгийн цаг уурын нөхцөл

VOLMET (Meteorological information for aircraft in flight) - Нислэг үйлдэж буй агаарын хөлөгт өгөх цаг уурын мэдээ

VOR (VHF omnidirectional radio range) – VOR (Бүх чиглэлтэй хэт өндөр давтамжийн радио дохиологч)

VSM (Vertical separation minimum) – VSM (Босоо зайчлалын минимум)

VSWR (Voltage standing wave ratio) – Долгионы харьцааг вольтоор илэрхийлэх

ZFT (Zero flight time) - Нислэгийн цаггүй
